УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

БАГА НАСНЫ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ЧИХРИЙН АГУУЛАМЖТАЙ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШОШГЫН СТАНДАРТ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЗӨВЛӨМЖ

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-23/205

Хянасан:	Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (ПССХ)-гийн захирал Ц.Цогзолмаа
Судалгаа удирдсан:	ПССХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, ахлах зөвлөх Ц.Норовдондог (Ph.D.)
Судалгаа нэгтгэсэн:	ПССХ-ийн ахлах референт О.Нарантуяа
Судлаачид:	Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, Э.Дашзэгвэ, Р.Оргилмаа

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....2

УДИРТГАЛ.....3

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ.....4

СУДАЛГААНЫ ХЭСЭГ.....10

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....10

ХОЁР.ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШОШГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ЗӨВЛӨМЖ

2.1.Олон улсын зохицуулалт.....13

2.2.Олон улсын зөвлөмж, стандарт.....14

2.3.Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж.....16

ГУРАВ.ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШОШГЫН СТАНДАРТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

3.1.Европын Холбоо.....18

3.2.Австрали, Шинэ Зеланд Улс.....22

3.3.Америкийн Нэгдсэн Улс.....27

3.4.Бүгд Найрамдах Солонгос Улс.....32

3.5.Канад Улс.....38

3.6.Монгол Улс.....42

АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....47

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага

УДИРТГАЛ

“Бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгын стандарт: олон улсын туршлага, зөвлөмж” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгын стандарт, чихрийн агууламжийн талаарх эрх зүйн орчин, холбогдох зохицуулалтын талаар Монгол Улсын болон гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Сэдвийн хүрээнд захиалагчийн хүсэлтийн дагуу бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошго, түүнд тавигдах шаардлага, стандарт, хууль, эрх зүйн орчны талаарх мэдээллийг харьцуулан судалсан болно. Судалгаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хүнсний эрх зүйн комисс болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаа, зөвлөмж, стандартууд, түүнчлэн Монгол Улс, Европын холбоо, Австрали-Шинэ Зеланд, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Канад Улс зэрэг орнуудын холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон бусад мэдээллийн эх сурвалжуудыг ашиглав.

Судалгааны бүтэц: Судалгаа нь Хураангуй болон Үндсэн 3 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, ерөнхий мэдээлэл буюу чихрийн тодорхойлолт, төрөл, хүнсний шошгын талаар, Хоёрдугаар хэсэгт, Хүнсний бүтээгдэхүүний шошгын олон улсын стандарт, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн талаар, Гуравдугаар хэсэгт, Монгол Улс болон гадаадын зарим орны хүнсний бүтээгдэхүүний шошгын стандарт, эрх зүйн орчны талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: шошго, шошгын стандарт, шошгын тусгай шаардлага, чихрийн агууламж, шим тэжээл, нүүрс ус, орц найрлага, хоол тэжээлийн шошго, чихэр, моносахар, дисахар, хүүхдэд зориулсан, нярай хүүхэд, бага насны хүүхэд

Key words: Labelling, label standart, free sugar, ingredients, nutrient, nutrition claims, nutrition labelling, standard for sugars, added sugar, total sugar, mono-saccharides, di-saccharide, food standard, for children, infants, youth children

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас XXI зууны өвчин хэмээн нэрлэгдэх болсон чихрийн донтолт, амттай “хор”-ын хэрэглээ хэтэрч хүн амын өвчлөлийн суурь шалтгаан болж, энэ нь зөвхөн нэг улсын асуудал биш дэлхий нийтийн асуудал болж буйг анхааруулсаар байна.

Чихэр болон чихрийн хэрэглээ. Чихэр нь байгалийн гаралтай чихэр болон чихэр гэж хоёр хуваагддаг. Байгалийн гаралтай чихэр бүх төрлийн жимс, хүнсний ногоо, сүүн бүтээгдэхүүнд байдаг бөгөөд энэ төрлийн чихэр нь бидний эрүүл мэндэд төдийлөн хор хөнөөл учруулдаггүй. Харин чихэр нь хоол хүнс, ундаанд нэмдэг чихэр, жимсний шүүс, зөгийн бал, сироп зэрэгт агуулагддаг бөгөөд хэтрүүлэн хэрэглэх нь эрүүл мэндэд хортой учраас бага хэрэглэхийг зөвлөдөг байна. Чихэр нь нүүрс усны нэг төрөл бөгөөд янз бүрийн хүнсний бүтээгдэхүүнд байдаг бүрэлдэхүүн хэсэг юм. Нүүрс усыг нийлмэл ба энгийн гэсэн хоёр үндсэн бүлэгт ангилдаг. Нийлмэл нүүрс ус нь химийн нэгдлээр холбогдсон олон тооны чихрийн молекулаас бүрддэг.

Чихэр нь маш бага тэжээллэг чанартай бөгөөд найрлага, гарал үүслийн шинж чанараараа олон төрөл байдаг учраас шим тэжээлийн мэдээлэлд тэдгээрийг ялган бичих нь чухал байдаг. Тиймээс Их Британийн Зүрхний сангаас чихрийн 50 нэршлийн[1] жагсаалтыг гаргасан байна.

ДЭМБ-аас “Насанд хүрэгчид болон хүүхдийн чихрийн хэрэглээ”-ний талаарх удирдамжийг 2015 онд гаргасан бөгөөд тус байгууллагын тодорхойлсноор, чихэр гэж үйлдвэрлэгч, тогооч, хэрэглэгчээс хүнс, ундаанд нэмдэг моносахар, дисахар, зөгийн бал, сироп, жимсний шүүс, жимсний шүүсний баяжмалд агуулагдах чихрийг ойлгоно. Тус байгууллагаас хүний өдөрт авах чихрийн нийт хэмжээ нь илчлэгийн 10 хувиас доош байх тохиолдолд илүүдэл жин, таргалалт, шүд цоорох өвчлөлийн эрсдэл буурдаг талаар мэдээллэж, цаашид 7-8 хувьд хүргэж бууруулахийг зөвлөж байна. Мөн бага насны хүүхдийн чихрийн зохистой хэрэглээг тодорхойлсон зөвлөмжийн дагуу 12 сараас доош насны хүүхдийн хүнсэнд чихрийг хориглохыг зөвлөж байна. (Жич: Монгол Улсын “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” стандартад “чихэр /сахар/ гэж хүнсэнд агуулагдах моносахар болон дисахарыг ойлгоно” гэж тодорхойлсон байх тул судалгаанд хэрэглэсэн ”чихэр” хэмээх нэр томьёог чихэр/сахар хэмээн ойлгоно уу.)

Хүнсний шошгын стандарт. Чихрийн хэрэглээгээ бууруулахын тулд шим тэжээлийн шошго, орц найрлагын талаарх мэдээлэл чухал юм. Хүнсний бүтээгдэхүүний шошго буюу хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл өгөх, зөв сонголт хийх боломжийг олгодог. Хүнсний шошго гэж хүнсний бүтээгдэхүүний саванд бичигдсэн, хэвлэсэн, тэмдэглэсэн, товойлгон дарсан, эсхүл хавсаргасан аливаа шошго, брэнд, тэмдэг, зураг болон бусад тодорхойлолт юм. Хүнсний шошго нь тухайн бүтээгдэхүүний онцлог шинж чанар, агуулга болон түүнийг хэрхэн зохицуулах, бэлтгэх, аюулгүй хэрэглэх тухай мэдээллийг агуулдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ) болон ДЭМБ хүнсний шошгололттой холбоотой бодлогын болон техникийн асуудлаар зөвлөгөө өгч ажилладаг **Хүнсний эрх зүйн комисс**[2] (Codex Alimentarius Commission)-ийг 1963 онд хамтран байгуулсан бөгөөд эдүгээ хүнсний стандартын

[1] https://www.bhf.org.uk/informationsupport/heart-matters-magazine/nutrition/sugar-salt-and-fat/names-for-sugar-infographic

[2] https://news.zindaa.mn/2cwf

чиглэлээр ажилладаг олон улсын хамгийн том байгууллага (188 улс гишүүнээр элссэн) болсон. Одоогийн байдлаар Хүнсний эрх зүйн комисс нь шим тэжээл болон шошготой холбоотой 232 стандарт, 85 удирдамж баталсан бөгөөд эдгээрийг дэлхийн улс орнууд удирдамж болгон ашигладаг.

Хүнсний бүтээгдэхүүний шошго нь ямар мэдээлэл агуулж байгаагаас хамаарч өөр өөр нэршилтэй байдаг. Тухайлбал, Шим тэжээлийн шошго, Хүнсний хог хаягдлыг бууруулах хүнсний шошго, Хүнсний гарал үүслийн шошго гэх мэт.

Хүнсний эрх зүйн комиссоос бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой дараах удирдамж, стандартыг баталсан байна. Тухайлбал,

- Шим тэжээлийн шошгын талаарх удирдамж;
- Нярай болон бага насны хүүхдэд зориулсан нэмэлт хоол тэжээлийн талаарх удирдамж;
- Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоолны дэглэмийн тусгай хэрэглээнд хэрэглэх шим тэжээлийн нэгдлүүдийн зөвлөмжийн жагсаалт;
- Нярай болон бага насны хүүхдэд зориулсан боловсруулсан үр тарианд суурилсан хүнсний стандарт;
- Чихрийн стандарт.

Дээр дурдсан стандарт, удирдамжид бага насны хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний шошго дээр чихэр, эсхүл нүүрс усны хэмжээг заавал тэмдэглэсэн байх, зарим тохиолдолд чихрийн талаарх тусгайлсан мэдээлэл оруулахыг шаардсан байна. Тухайлбал, Чихрийн стандартад дурдсанаар, глюкозын сироп нь 5 хувиас дээш фруктоз агуулсан бол түүний талаарх тайлбарыг агуулсан байх тусгай шаардлага тавьдаг байна.

Судалгааны үр дүнгийн тойм

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгын стандартын асуудлыг зохицуулсан бие даасан хууль байхгүй байгаа бөгөөд улс орон бүр буюу хүнсний тухай болон хүнсний аюулгүй байдлын тухай хууль гэх мэт үндэсний хууль тогтоомж, стандарт, дүрэм журмаар зохицуулж байна.

Хүнсний бүтээгдэхүүний шошгод бүтээгдэхүүний орц, найрлага, шим тэжээлийн мэдээллийг тэмдэглэх нийтлэг шаардлагыг Хүнсний эрх зүйн хороо болон үндэсний эрх зүйн хууль тогтоомжоор тогтоодог байна. Харин бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгын хувьд дээрх нийтлэг шаардлагаас гадна үндэсний хууль тогтоомжоор тусгайлсан шаардлагыг тавьдаг практик байна. Тухайлбал, бага насны хүүхдийн хоол, хүнсэнд агуулагдах чихэр, зөгийн балны моносахар, дисахарын агууламж 4гр/100 гр-аас их байвал тухайн хүнсийг “чихэрлэг” гэх, ”чихэр агуулаагүй”, “чихрийн агууламжгүй” зэрэг мэдэгдлүүд, мөн орц найрлагадаа илтэд чихрийн агууламжтай хоол хүнсэнд, ялангуяа нярай болон 2-оос доош насны хүүхдэд тусгайлан зориулсан хоол хүнсний шошго дээр дээрх байдлаар мэдээллийг ерөнхий агуулгаар тавихыг хориглодог гэх мэт тусгай шаардлагуудыг дурьдаж болно.

Судалгаанд авагдсан орнуудын хувьд, нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүн дэх чихрийн агууламж болон шошгод тусгайлсан шаардлага тавьдаг орнууд бөгөөд нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүнд чихрийн агууламжийг хязгаарлах, хориглох зохицуулалттай байна. /Мэдээллийн харьцуулалтыг Хүснэгт 1-ээс үзнэ үү./

Судалгаанд авагдсан орнуудын зарим онцлох туршлага:

Европын Холбооны хувьд, нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод тавих нийтлэг болон тусгай шаардлагыг дүрмээр зохицуулдаг.

Европын холбооны хэмжээнд Хэрэглэгчийг хүнсний бүтээгдэхүүний мэдээллээр хангах тухай дүрэм (FIC) 2014 оноос хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус дүрмээр хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын шошгод тавих нийтлэг болон тусгай шаардлагыг зохицуулсан. Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүн, түүний дотор чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгонд тусгай шаардлага зарим нэгэн тусгайлсан шаардлага тавигддаг. Тухайлбал, хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошго дээр чихрийн хэмжээг заавал бичихийг шаарддаг бөгөөд 3-аас доош насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошго дээр чихэр багатай, чихрийг багасгасан гэх мэт чихрийн агууламжийн талаар ерөнхий агуулгатай мэдээлэл оруулахыг хориглодог.

Хүнсний нэмэлтийн тухай хуулиар тусгайлан зааснаас бусад тохиолдолд хүнсний нэмэлт, нэмэлт чихрийг нярай болон бага насны хүүхдийн хоол тэжээлд хэрэглэхийг мөн хориглосон.

Австрали-Шинэ Зеланд Улсын хувьд, Австрали-Шинэ Зеландын бүх муж, нутаг дэвсгэрийн хэмжээнд Австрали, Шинэ Зеландын Хүнсний стандартын тухай хууль, Хүнсний стандартын дүрмийг (Food Standards Code) дагаж мөрддөг. Уг дүрмээр бүх хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагчдад зориулсан заавал байх ёстой хүнсний нэмэлт, шошгын стандартаас гадна үйлдвэрлэлийн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтад тавигдах шаардлагыг тогтоожээ. Тус дүрмийн 2 дугаар бүлэгт хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний чихрийн агууламж, шошгын стандартыг тогтоосон байдаг.

Дүрэмд зааснаар савласан хүнсний бүтээгдэхүүний шошгон дээр орц найрлага, шим тэжээлийн үзүүлэлт, агууламжийн хэмжээ зэрэг шим тэжээлийн мэдээллийг тавихыг шаарддаг. Мөн чихрийн агууламжийг тодорхойлох шошгын бас нэгэн стандарт нь Эрүүл мэндийн одны үнэлгээний систем юм. Тухайлбал, энгийн ус 5 од бол, 100% жимс, ногооны шүүс 2.5-аас 4 од гэх мэтээр тэмдэглэдэг.

Нярай болон бага насны хүүхдийн хооллолтын удирдамж (Eating for Health Babies and Toddlers)-д бага насны хүүхдэд (0-2 нас) чихрийн агууламж бүхий хоол тэжээл өгөхөөс татгалзахыг зөвлөдөг бол, Хүнсний стандартын дүрэмд 12 хүртэлх сартай нярайд зориулсан хүнсний бүтээгдэхүүний найрлагад чихэр нэмэхийг хориглодог.

Америкийн Нэгдсэн Улсын хувьд, нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод тавих нийтлэг болон тусгай шаардлагыг Холбооны журмуудын код (Code of Federal Regulations)-оор зохицуулдаг. Уг кодын 21-р бүлэг (Хүнс болон эм) болон 101 дүгээр хэсэг (Хүнсний шошго)-т хүнсний бүтээгдэхүүний найрлага дахь шимт бодисын хоногт хэрэглэх зөвлөмжид нэмэлт чихрийн агууламжийг 1-3 хүртэлх насны хүүхдэд 25 гр хүртэл зөвшөөрсөн бол, 12 сар хүртэлх нярайн хоол тэжээлд нэмэлт чихэр хийхийг хориглосон байна. Мөн “чихэр агуулаагүй”, “чихрийн агууламжгүй” зэрэг мэдэгдлүүдийг, орц, найрлагадаа илтэд чихрийн агууламж бүхий хоол хүнсэнд, ялангуяа нярай болон 2-оос доош насны хүүхдэд тусгайлан зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошго дээр тавихыг хориглосон.

Хэрэглэгчдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй хүнс сонгоход нь туслах үүднээс хүнсний бүтээгдэхүүний савлагааны нүүрэн хэсэгт тухайн хүнсний бүтээгдэхүүн дэх хүний биед нэн шаардлагатай шим тэжээлийн хэмжээг ойлгоход хялбар байдлаар мэдээлдэг байна. Хүнс үйлдвэрлэгчдийн холбооноос анх санаачилан хэрэгжүүлсэн тус нүүрэн талын шошгыг одоогоор хуульчлаагүй, хүнс үйлдвэрлэгчид сайн дурын үүднээс мэдээлдэг бөгөөд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах ажил хийгдэж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд, хүнсний хэрэгцээнийхээ 45 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангадаг улс юм. Бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошготой холбоотой харилцааг Хүүхдийн дуртай хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага ба шошгын стандартын тухай журмаар зохицуулдаг. Тус журамд шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн шошгололт, аргачлалыг тогтоосон. Шошгын мэдээллийг хялбар байдлаар хэрэглэгчдэд таниулахын тулд дэвсгэрийн өнгөнөөс ялгаатай өнгөөр харуулах ёстой бөгөөд уг бүтээгдэхүүний анхны шошгыг халхлах ёсгүй. Мөн шим тэжээлийн бүрэлдэхүүн тус бүрийн өнгөний стандартыг ногоон, цагаан, улаан өнгөөр ялгахаар, шим тэжээлийн бүрэлдэхүүний хэмжээг илэрхийлэх гэх мэт загварын стандартыг ашигладаг байна.

Канад Улсын хувьд, бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой харилцааг Хүнс, эмийн тухай хуулиар зохицуулдаг. 6-12 сар хүртэлх насны хүүхдийн савласан хүнсний бүтээгдэхүүнд өөх тос, эслэг, элсэн чихэр, холестерол, натри, ханасан тосны хүчил, транс тосны хүчлийг хориглох бөгөөд 2 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн шошгонд өөх тос, натри, нүүрс ус, эслэг, чихэр, уураг, А аминдэм, витамин С, кальци, төмрийн орц найрлагыг тодорхой тусгадаг байна. Нярай болон 1-4 насны хүүхэд, жирэмсэн эхчүүдэд чихрийн орц, найрлагыг зөвшөөрдөггүй. Тус улсын хувьд хүнсний бүтээгдэхүүний шошгын шаардлагын хяналтын хуудсыг ашигладаг бөгөөд энэ нь хүнсний хяналтын агентлагаас зөвшөөрөгдсөн шим тэжээлийн агууламжийг баталгаажуулах, хүүхэд, насанд хүрэгчдийн хүнсний бүтээгдэхүүнээс авч байгаа илчлэг, шим тэжээлийн хэмжээнд хяналт тавих боломжтой болдог байна.

Монгол Улсын хувьд, хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгод олон улсын болон дотоодын хууль тогтоомжид заасан стандартыг дагаж мөрдөж байна. Бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн болон найрлагын үзүүлэлт, шошгын стандартыг Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль, Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам, Монгол Улсын стандарт: “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага”-д заасан нийтлэг болон тусгай шаардлагыг дагаж мөрддөг. Бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошго нь шим тэжээл, орц найрлагаас гадна илүү нарийвчилсан нэмэлт мэдээллийг шаарддаг онцлогтой бүтээгдэхүүн юм.

Манай улсын хувьд, 6 сартайгаас 3 хүртэлх насны хүүхдийн хүнсний найрлагад зөгийн бал болон байгалийн гаралтай чихэр агуулсан байхыг зөвшөөрдөг бол бусад орнуудад нярай буюу 12 хүртэлх сартай хүүхдэд сахар, зөгийн балны агууламжтай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийг хориглодог, бага насны буюу 3 хүртэлх насны хүүхдэд тодорхой хэмжээгээр хязгаарладаг зохицуулалттай байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү)

Хүснэгт 1. Нярай болон бага насны хүүхдийн хүнсэн дэх чихрийн агууламж, шошгын зохицуулалтын талаарх харьцуулсан мэдээлэл

Улсын нэр	Хууль тогтоомжийн нэр	Тодорхойлолт	Шошгод тавигдах тусгай шаардлага	Чихрийн агууламжийн талаарх тусгай зохицуулалт
Монгол Улс	- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль - Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль - “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” Монгол Улсын стандарт	Нялх хүүхэд гэж төрснөөс хойш нэг хүртэлх насны хүүхдийг, балчир хүүхэд гэж нэгээс гурав хүртэлх насны хүүхдийг ойлгоно.	Дараах нэмэлт мэдээллийг тавьсан байна. -шошгын нүүрэн хэсэгт бүрээгдэхүүнийг хэрэглэх нас; -бэлтгэх, хадгалах горим алдагдсантай холбоотой үүсэх эрүүл мэндийн эрсдэлийг сануулсан анхааруулгыг "САНАМЖ" гарчгийн доор; -энэ бүтээгдэхүүнийг 6 сар хүртэлх насны хүүхдэд өгч болохгүй тухай анхааруулга; -хэрэглэх зааврын хажууд "ДАВС, ЭСХҮЛ ЧИХЭР НЭМЖ БОЛОХГҮЙ" гэсэн мэдээлэл том үсгээр.	Зургаан сартайгаас гурав хүртэлх насны хүүхдийн хүнсний найрлагад зөгийн бал болон байгалийн гаралтай чихэр агуулсан байж болох бөгөөд транс тос, хувиргасан амьд организмаас гаралтай түүхий эд ашиглахыг хориглоно.
Европын Холбоо	- Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоол тэжээл, эмнэлгийн тусгай зориулалтын хоол хүнсний тухай тусгай дүрэм - Нялхсын хоол тэжээл, нэмэлт тэжээлд тавигдах тусгай найрлага, мэдээллийн шаардлага, нярай болон бага насны хүүхдийн хооллолттой холбоотой мэдээллийн шаардлагын талаарх нэмэлт дүрэм	“Нярай (Infant) гэж 0-12 сар хүртэлх, бага насны хүүхэд (Young child) гэж 01-ээс 3 хүртэлх настай хүүхдийг ойлгоно.	Чихрийн агууламжийн мэдэгдэл: -Насанд нь тохируулан хэрэглэх хэмжээ; -Энгийн ойлгомжтой хэллэг ба дүрслэл; -Эрүүл мэндийн хамаарлын заалт; -Харшил төрүүлэгчийн мэдээлэл;	Хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод "чихэр багатай" (low in sugar) эсвэл "чихрийг нь багасгасан" (reduced sugar) гэх мэт чихрийн агууламжийн талаар эрүүл мэндтэй холбоотой ямар нэгэн заалт оруулж болохгүй. Ялангуяа 3-аас доош насны хүүхдэд зориулсан бүтээгдэхүүнд ийм заалтыг огт зөвшөөрдөггүй.
Австрали-Шинэ Зеланд Улс	- Австрали-Шинэ Зеландын Хүнсний стандартын дүрэм - “Савласан хүнсний бүтээгдэхүүн болон ундааны чихрийн үзүүлэлтийн талаарх мэдээлэл” бодлогын баримт бичиг - Хэрэглэгчдэд эрүүл сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх хүнсний шошгын талаар баримтлах бодлогын удирдамж	Нярай гэж 12 сар хүртэлх насны хүүхэд, 12 сараас дээш насны хүүхдэд зориулсан хоол хүнсний найрлагад ижил шаардлага тавьдаггүй.	Бага насны хүүхдийн хоолонд агуулагдах элсэн чихэр, зөгийн балны моносахар, дисахаридын агууламж 4 г/100 гр-аас их байвал тухайн хүнсийг "чихэрлэг" гэж тодорхойлсон шошготой байх шаардлагатай. Мөн нярай хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний савлагаанд хэрэглэх заавар, анхааруулга мэдэгдлийг заавал бичнэ.	12-оос доош насны хүүхдийн хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүнд чихрийн агууламжийг хориглодог.
АНУ	- Холбооны Хүнс, Эм, Гоо сайхны бүтээгдэхүүний тухай хуулийн IV	Нярай гэж 12 сар хүртэлх хүүхэд,	“чихэр агуулаагүй”, “чихрийн агууламжгүй” зэрэг мэдэгдлүүдийг, орц, найрлагандаа илтэд	Нярай хүүхдийн сүүнээс бусад, 12 сар хүртэлх нярай болон 1-3

	бүлэг - Шударгаар савлах болон шошголох тухай хууль - Шим тэжээлийн шошго болон түүний талаар мэдлэг олгох тухай хууль-Холбооны журмын 21-р бүлэг Хүнс болон эм, 101 Хүнсний шошго хэсэг	Бага насны хүүхэд гэж 1-3 нас хүртэлх хүүхдийг ойлгоно.	чихрийн агууламж бүхий хоол хүнсэнд, ялангуяа нярай болон 2-оос доош насны хүүхдэд тусгайлан зориулсан хоол хүнсний шошго дээр тавихыг хориглоно.	нас хүртэлх хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод шимт бодисыг заавал мэдээлсэн байна. Шимт бодисын мэдээлэлд илчлэг, нийт тос, ханасан тос, транс тос, натри, нийт нүүрс ус, хүнсний эслэг, нийт чихэр, нэмэлт чихэр, ууураг, болон дараах витамин, эрдэс бодисуудыг заавал багтаасан байна: витамин Д, кальци, төмөр болон кали гэж заажээ.
БНСУ	- Хүүхдийн хоол тэжээлийн аюулгүй байдлын хяналтын тухай тусгай хууль, - Хүүхдүүдийн дуртай хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага болон шошгын стандартын тухай журам, - Хүнсний бүтээгдэхүүний шошгын стандарт	Нярай гэж 0-3 насны хүүхэд, Бага насны хүүхэд гэж 3-6 хүртлэх насны хүүхдийг ойлгоно.	Шим тэжээлийн найрлагад орцын хувийг тэмдэглэсэн байх ёстой. 2-оос дээш порцтой бүтээгдэхүүний хувьд нийт порцын хэмжээг зааж өгнө. (1 порц пицца 8 зүсэм: нэг зүсэм нь 150 гр орчим (нэг зүсмийн хэмжээ 100-299 гр)) гэж ойролцоогоор бичнэ) Хоёр ба түүнээс дээш төрлийн хүнсний бүтээгдэхүүнээс бүрдсэн бол нийт илчлэгийг заана. Гэхдээ хэд хэдэн төрлийн хүнсний бүтээгдэхүүний хувьд нийт калорийн хамгийн бага ба хамгийн их утгыг зааж өгнө.	Хүүхдийн дуртай хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн найрлага, нийт хэмжээг өнгө, хэлбэр дүрсээр харуулах стандартыг журмын хавсралтаар баталсан.
Канад Улс	Хүнс, эмийн тухай хуулийн хоёрдугаар бүлэг Дэд хэсэг “6-12 сар хүртэлх хүүхдийн хоол тэжээлийн шошго”	Нярай гэж 6-12 сар хүртэлх хүүхдийг ойлгоно.	2 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн шошгонд өөх тос, натри, нүүрс ус, эслэг, чихэр, ууураг, А, С аминдэм, кальци, төмрийн орц найрлагыг тодорхой тусгана. Чихрийн химийн орц найрлага, чихрийн төрөл, нэршил зэргийг нарийвчлан тусгаж өгсөн байна.	6-12 сар хүртэлх хүүхдийн савласан бүтээгдэхүүнд өөх тос, эслэг, элсэн чихэр, холестерол, натри, ханасан тосны хүчил, транс тосны хүчлийг агуулж болохгүй.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас гаргасан судалгаанаас үзэхэд, XXI зууны өвчин хэмээн нэрлэгдэх болсон чихрийн донтолт, амттай “хор”-ын хэрэглээ хэтэрч хүн амын өвчлөлийн суурь шалтгаан болж, энэ нь зөвхөн нэг улсын асуудал биш дэлхий нийтийн асуудал болж байна. Дэлхий дээр жилд 200 сая тонн чихэр үйлдвэрлэгддэг бөгөөд энэ нь 7 тэрбум хүн тус бүрт 25 кг чихэр ногдож байна. Өөрөөр хэлбэл, энэ нь өдөрт 1 хүнд 17 цайны халбага чихэр гэсэн үг юм.

Чихэр нь байгалийн гаралтай чихэр болон чихэр гэж хоёр ангилагдана. Байгалийн гаралтай чихрийн хувьд бүх төрлийн жимс, хүнсний ногоо, сүүн бүтээгдэхүүнд байдаг бөгөөд энэ төрлийн чихэр нь бидний эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаггүй. Харин чихэр нь хоол хүнс, ундаанд нэмдэг чихэр, жимсний шүүс, зөгийн бал, сироп зэрэгт агуулагддаг, бага хэрэглэхийг зөвлөдөг бөгөөд хэтрүүлэн хэрэглэх нь эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаг.

Чихэр нь нүүрс усны нэг төрөл бөгөөд хүнсний бүтээгдэхүүний бүрэлдэхүүнд орж байдаг. Нүүрс усыг нийлмэл ба энгийн гэсэн хоёр үндсэн бүлэгт ангилдаг. Нийлмэл нүүрс ус нь химийн нэгдлээр холбогдсон олон тооны чихрийн молекулаас бүрддэг.

Энгийн нүүрс ус нь **моносахар** (нэг чихрийн молекул), эсхүл **дисахар** (хоёр чихрийн молекул)[3] хэлбэртэй бөгөөд эдгээр нь цусанд хурдан шингэдэг. Моносахар нь глюкоз ба фруктозоос бүрддэг. Дисахар нь сахароз ба лактозоос бүрддэг байна. **Глюкоз** нь таны биеийн эрчим хүчний гол эх үүсвэр юм.

Фруктоз буюу жимсний сахар нь жимс, зөгийн бал, сахароз, фруктоз өндөртэй эрдэнэ шишийн сироп зэрэгт байдаг байгалийн гаралтай энгийн элсэн чихэр юм. Фруктоз нь маш чихэрлэг бөгөөд сахарозоос (цагаан элсэн чихэр) бараг 1.5 дахин чихэрлэг юм. Дэлхий даяар фруктозын өндөр агууламжтай эрдэнэ шишийн сироп агуулсан зөөлөн ундаа, хүнсний чихэрлэг амтлагчийн хэрэглээ ихэссэн тул фруктозын хэрэглээ 1900-аад оны эхэн үеэс дөрөв дахин нэмэгдсэн байна.

Сахароз нь чихрийн нишингээс үйлдвэрийн аргаар гаргаж авсан талстжисан цагаан элсэн чихэр бөгөөд дэлхий нийтээр түгээмэл хэрэглэдэг. Сахароз нь 50% глюкоз, 50% фруктозоос бүрдэх дисахарид бөгөөд түүний бүрэлдэхүүн хэсгүүд хурдан задардаг. Сахароз нь глюкозын агууламжаас шалтгаалан цусан дахь сахарын хэмжээг ихэсгэдэг бөгөөд чихрийн шижин өвчтэй хүмүүс сахароз агуулсан хоол хүнсийг анхаарах шаардлагатай.

Лактоз бол сүүнд агуулагддаг чихэр юм. Энэ нь глюкоз ба галактозын нэгжээс бүрддэг дисахарид юм.

Чихэр нь өөрөө маш бага тэжээллэг чанартай бөгөөд олон төрлийн чихэр байдгийг ойлгох нь чухал юм. Шошго дахь шим тэжээлийн найрлагын жагсаалтаас чихрийг хэрхэн олох нь тийм ч амар биш бөгөөд энэ нь олон янзын нэршлээс үүдэлтэй. Тухайлбал, Британийн Зүрхний сангаас чихрийн 50 нэршлийн[4] жагсаалтыг гаргасан байна.

Зураг 1.Чихрийн нэршлийн жагсаалт

[3] https://www.bbcgoodfood.com/howto/guide/sugar-explained

[4] https://www.bhf.org.uk/informationsupport/heart-matters-magazine/nutrition/sugar-salt-and-fat/names-for-sugar-infographic





Чихрийн хэрэглээгээ бууруулахын тулд юуны өмнө шим тэжээл болон орц найрлагын талаарх мэдээлэл, шошгын талаар мэдэх нь чухал юм.

Сүү, жимс жимсгэнэ, хүнсний ногоо зэрэг байгалийн гаралтай чихрийн хэрэглээг багасгах шаардлагагүй хэдий ч, хүнсний шошгон дээр байдаг нийт чихэр гэсэн хэмжээнд энэ нь багтдаг тул чихрийн найрлагын талаар илүү дэлгэрэнгүй мэдэх нь чухал. Үүнд:

- **Чихэр** гэж хоол хүнсэнд агуулагдах моносахар (mono-saccharides) болон дисахар (di-saccharide)-ийг хэлнэ.
- **Нийт чихэр (Total sugar)** гэж лабораторийн аргаар хэмжсэн хүнсний бүтээгдэхүүнд нэмсэн байгалийн гаралтай бүх чихрийн хэмжээг хэлнэ.
- **“of which sugars”** гэсэн тэмдэглэгээ нь бүх эх үүсвэрт агуулагдах чихрийн нийт хэмжээг илэрхийлнэ.
- **Нэмэлт чихэр** (Added sugar) гэж хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, айл өрх, гуанз, ресторанд хоол хийх явцад нэмдэг чихэр юм.

Бүтээгдэхүүн нь дараах босго хэмжээнээс дээш, эсхүл доош байвал чихэр ихтэй, эсхүл багатай гэж үзнэ. Тухайлбал[5],

- Өндөр-100 грамм (гр) тутамд нийт чихэр 22.5 гр-аас дээш;
- Бага-100 гр тутамд 5 гр буюу түүнээс бага;
- Хэрэв 100 гр дахь чихрийн хэмжээ дээрх үзүүлэлтүүдийн хооронд байвал үүнийг дунд зэрэгт тооцно.

Бүтээгдэхүүний орцын найрлагаас хүнсний бүтээгдэхүүнд чихэр хэр хэмжээтэй байгааг мэдэх боломжтой. Хоол хүнс, ундаанд нэмдэг чихэр нь орцын жагсаалтад заавал байх ёстой бөгөөд жагсаалт нь хамгийн их орц бүхий найрлагаас бага орц руу буурсан дараалалтай бичигдсэн байдаг.

[5] https://www.nhs.uk/live-well/eat-well/food-types/how-does-sugar-in-our-diet-affect-our-health/

Хүнсний бүтээгдэхүүний шошго: Техник технологийн дэвшлийн ачаар хүн төрөлхтөн тоо томшгүй олон сонголт, хүлээлтэд нийцсэн хоол хүнсийг үйлдвэрлэж, хэрэглэх боломжтой болсон. Нөгөө талдаа тэрхүү олон сонголтоос өөрийн эрүүл мэнд, хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг сонгон авах нь бэрхшээлтэй тулгардаг. Шим тэжээл, орц найрлага зэрэг хүнсний бүтээгдэхүүний шошгон дээрх мэдээлэл нь хэрэглэгчдэд мэдлэг, мэдээлэлтэйгээр сонголт хийх боломжийг олгож байна. Дэлхийн худалдаа нэмэгдэж, хүнсний үйлдвэрлэгч, худалдан авагчийн нүүр тулан худалдан авалт хийдэг уламжлалт арга холдож байгаа энэ үед хүнсний бүтээгдэхүүний шошгыг ойлгомжтой, найдвартай болгох шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Хүнсний шошго гэж юу вэ?[6] Хүнсний бүтээгдэхүүний шошго буюу хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь хэрэглэгчдэд шууд мэдээлэл хүргэх хамгийн чухал хэрэгслийн нэг юм. Хүнсний шошгын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт нь хүнсний бүтээгдэхүүний саван дээр бичигдсэн, хэвлэсэн, тэмдэглэсэн, товойлгон дарсан, эсхүл хавсаргасан аливаа шошго, брэнд, тэмдэг, зураг болон бусад тодорхойлолт юм. Хүнсний шошго нь тухайн бүтээгдэхүүний онцлог шинж чанар, агуулга болон түүнийг хэрхэн зохицуулах, бэлтгэх, аюулгүй хэрэглэх тухай мэдээллийг агуулдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-аас хүнсний бүтээгдэхүүний шошгололтыг хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн хувьд хэрэглэгчийн эрүүл мэндийг хамгаалах үр дүнтэй хэрэгсэл гэж үзсэн байна.

[6] https://www.fao.org/food-labelling/en/

ХОЁР.ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШОШГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ЗӨВЛӨМЖ

2.1.Олон улсын зохицуулалт

НҮБ-ын ХХААБ болон ДЭМБ хамтран хүнсний шошгололттой холбоотой бодлогын болон техникийн асуудлаар зөвлөгөө өгч ажилладаг **Хүнсний эрх зүйн комисс** (Codex Alimentarius Commission)-ийг 1963 онд байгуулсан бөгөөд эдүгээ хүнсний стандартын чиглэлээр ажилладаг олон улсын хамгийн том байгууллага (188 улс гишүүнээр элссэн) болсон. Одоогийн байдлаар Хүнсний эрх зүйн комисс нь шим тэжээл болон шошготой холбоотой 232 стандарт, 85 удирдамж баталсан бөгөөд эдгээрийг дэлхийн улс орнууд удирдамж болгон ашигладаг. Хүнсний эрх зүйн комисс нь хүнсний бүтээгдэхүүний үндсэн шошго, үйлдвэрлэгчийн шошгон дээр "low fat", "high fat" гэх мэт нэр томьёо бүхий эрүүл мэнд, шим тэжээлийн талаарх мэдээлэл өгөхийг зөвлөмж болгодог.

Хүнсний шошгын кодексийн хороо (The Codex Committee on Food Labelling (CCFL)) нь бүх хүнсний бүтээгдэхүүнд хамаарах шошгын стандарт, удирдамжийг тогтоох үүрэгтэй Хүнсний эрх зүйн комиссын туслах хороо бөгөөд Урьдчилан савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтын ерөнхий стандарт (Codex General Standard for Labelling of Prepackaged Foods (CXS 1-1985))-ыг баталсан. Энэ нь хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх гол хэрэгсэл юм.

Тусгай хоолны дэглэмийн хэрэглээнд зориулсан шим тэжээл, хүнсний бүтээгдэхүүний Кодексийн хороо (CCNFSDU) нь хоол тэжээлийн дутагдал, хоолны дэглэмтэй холбоотой халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн техникийн болон зохицуулалтын өргөн хүрээний асуудлыг авч үздэг.

Хүнсний бүтээгдэхүүний шошго нь ямар мэдээлэл агуулж байгаагаас хамаарч өөр өөр нэршилтэй байна. Тухайлбал,

Шим тэжээлийн шошго: Шошго нь хэрэглэгчдэд эрүүл хүнсний сонголт хийхэд нь туслах үр дүнтэй хэрэгсэл бөгөөд нийгмийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн шим тэжээлийн шошго, эрүүл мэндийн шаардлагын боломжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд шошгыг зөв ойлгох, ашиглахад нь туслах зорилгоор сурталчилгааны ажил хийх, боловсролын хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Хүнсний эрх зүйн комиссын удирдамжид дараах төрлийн шим тэжээлийн шошгололтыг зөвлөж байна. Үүнд:

- Шим тэжээлийн мэдэгдэл (Nutrient Declaration)
- Шим тэжээлийн лавлах хэмжээ (Nutrient Reference Values)
- Найрлагын тоон мэдээлэл (Quantitative declaration on ingredients (QUID))
- Шим тэжээлийн мэдээлэл (Nutrition Claims)
- Эрүүл мэндийн мэдээлэл (Health Claims)

Шим тэжээлийн шошгыг шаардах болсон нэг гол хүчин зүйл бол хоолны дэглэмтэй холбоотой халдварт бус өвчний тархалт нэмэгдэж байгаа явдал юм. ДЭМБ-ын мэдээлснээр халдарт бус өвчин нь энэ зууны эрүүл мэнд, хөгжлийн хамгийн том сорилтуудын нэг болж байна гэж мэдээлжээ. Халдварт бус өвчний голлох өвчин нь зүрх судасны өвчин, цус харвалт, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин, түүнчлэн сэтгэцийн эрүүл мэндийн өвчнүүд хамаарч байна. Эдгээр өвчнүүд нь нийлээд дэлхий дээрх нас баралтын бараг ¾-ийг эзэлж, жилд 41 сая хүн нас барж байна. Үүнээс зүрх судасны өвчнөөр жилд 17.9 сая буюу 3 хүн тутмын 1 нь, чихрийн шижин өвчнөөр жилд 2 сая буюу 28 хүн тутмын 1 нь нас барж байна[7].

[7] https://www.who.int/teams/noncommunicable-diseases/invisible-numbers

Хүнсний хог хаягдлыг бууруулах хүнсний шошго: Хүнсний үйлдвэрлэгчид огнооны тэмдэглэгээг хүнсний сүлжээний операторуудад хүнсний хадгалах хугацааны талаар зөвлөгөө өгөх зорилгоор ашигладаг. Хүнсний эрх зүйн комиссоос огнооны талаар дараах 2 зааврыг өгдөг. Тухайлбал, “Best before date” or “Best quality before date” and ”Use-by-Date” or “Expiration date”. Шошгон дээр огноог тэмдэглэх нь хүнсний хог хаягдалтай ч холбоотой. Европын Комиссоос хийсэн судалгаагаар Европын холбооны хүнсний хог хаягдлын 10 орчим хувь нь огнооны тэмдэглэгээтэй холбоотой гэжээ. Нийлүүлэлтийн сүлжээний бүх оролцогч талуудад "best before" and "use by" хугацааны тэмдэглэгээг ашиглаж сурах нь хүнсний хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, багасгахад тусална гэж үзэж байгаа аж.

Хүнсний гарал үүслийн шошго: Газарзүйн заалт (GI)-ын шошго нь дэлхийн хэмжээнд жилд 50 тэрбум ам.доллараар үнэлэгддэг бөгөөд хүнсний бүтээгдэхүүнийг гарал үүсэлтэй нь холбож, хөдөө орон нутгийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны ач холбогдлыг хангадаг хууль, эрх зүйн хэрэгсэл юм. Эдгээр шошгыг газарзүйн гарал үүслээс үүдэлтэй тодорхой шинж чанар, эсхүл нэр хүнд бүхий бүтээгдэхүүнд өгдөг. Хүнсний соёлыг хадгалах, эрүүл хооллолтыг сурталчлах замаар хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг шошго тэмдэгтэй холбох нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ч дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой гэж ХХААБ үзэж байна.

2.2.Олон улсын зөвлөмж, стандарт

НҮБ-ийн Хүнсний эрх зүйн комиссоос бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгололт, чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой асуудлаар дараах зөвлөмж, стандартуудыг баталжээ. Үүнд:

Хүснэгт 2.Бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүн, шошгололтын талаар Хүнсний эрх зүйн хорооноос батлсан стандарт, зөвлөмж

Кодексийн дугаар	Стандартын нэр	Хариуцсан хороо	Сүүлийн өөрчлөлт орсон огноо
CXG 2-1985	Шим тэжээлийн шошгын талаарх удирдамж (Guidelines on Nutrition Labelling)[8]	CCFL	2021
CXG 8-1991	Нярай болон бага насны хүүхдэд зориулсан нэмэлт хоол тэжээлийн талаарх удирдамж (Guidelines on Formulated Complementary Foods for Older Infants and Young Children)[9]	CCNFSDU	2017
CXG 10-1979	Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоолны дэглэмийн тусгай хэрэглээнд хэрэглэх шим тэжээлийн нэгдлүүдийн зөвлөмжийн жагсаалт (Advisory Lists of Nutrient Compounds for Use in Foods for Special Dietary Uses intended for Infants and Young Children)[10]	CCNFSDU	2015
CXS 74-1981	Нярай болон бага насны хүүхдэд зориулсан боловсруулсан үр тарианд суурилсан хүнсний стандарт (Standard for Processed Cereal-Based Foods for Infants and Young Children)[11]	CCNFSDU	2019

[8] https://www.fao.org/fao-who-codexalimentarius/sh-proxy/en/?lnk=1&url=https%253A%252F%252Fworkspace.fao.org%252Fsites%252Fcodex%252FStandards%252FCXG%2B2-1985%252FCXG_002e.pdf

[9] https://resourcecentre.savethechildren.net/document/guidelines-on-formulated-complementary-foods-for-older-infants/

[10] https://www.isdi.org/wp-content/uploads/2020/04/CAC-GL-10-1979.pdf

CXS 212-1999	Чихрийн стандарт (Standard for Sugars)[12]	CCS	2019

CCFL-The Codex Committee on Food Labelling
CCNFSDU- The Codex Committee on Nutrition and Foods for Special Dietary uses
CCS- Codex Committee on Sugars

Шим тэжээлийн шошгын талаарх удирдамж (Guidelines on Nutrition Labelling)**:** Энэхүү удирдамжийн зорилго нь хэрэглэгчийг тухайн хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээллээр хангаж, зөв сонголт хийхэд туслах, шошгыг хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн талаарх мэдээлэл дамжуулах арга хэрэгсэл болгох, хүн амын эрүүл мэндэд тустай хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулахдаа зөв зохистой хооллолтыг дэмжих, шошго дээр нэмэлт мэдээллийг оруулах боломжоор хангах юм. Шим тэжээлийн шошго нь худал, төөрөгдүүлсэн, хууран мэхлэх, эсхүл ач холбогдол багатай бүтээгдэхүүнийг дүрслэхгүй байх, эсхүл түүний талаарх мэдээллийг өгөхийг хориглодог.

Удирдамжид зааснаар шошго дээр шим тэжээлийн мэдээлэл, нэмэлт шим тэжээлийн мэдээллийг агуулсан байх ёстой бөгөөд шим тэжээлийн жагсаалт, түүний хэмжээг нарийвчлан зааж өгсөн. Тухайлбал,

Шим тэжээлийн шошго нь шим тэжээлийн мэдээлэл (nutrient declaration), нэмэлт шим тэжээлийн мэдээлэл (supplementary nutrition information)-ээс бүрдэх бөгөөд мэдээллийн жагсаалт оруулсан байна. Чихэр гэж хоол хүнсэнд агуулагдах моносахар (mono-saccharides) болон дисахар (di-saccharide)-ийг хэлнэ гэж тодорхойлсон.

Шим тэжээлийн мэдээлэл хэсэгт илчлэг, уураг, нүүрс ус (хүнсний эслэгээс бусад нүүрс ус), өөх тос, ханасан өөх тос, натри, нийт чихрийн хэмжээ болон бусад шим тэжээлийн бодисын хэмжээ, үндэсний хууль тогтоомж эсхүл үндэсний хоол тэжээлийн удирдамжийн дагуу хоол тэжээлийн зохистой байдлыг хангахад чухал ач холбогдолтой бусад шим тэжээлийн бодисын хэмжээг заавал тусгасан байна.

Нярай болон бага насны хүүхдэд зориулсан нэмэлт хоол тэжээлийн удирдамж (Guidelines on Formulated Complementary Foods for Older Infants and Young Children)**:**

Энэхүү удирдамжийг нярай болон бага насны хүүхдийн хооллолтын дэлхийн стратеги болон Дэлхийн эрүүл мэндийн Ассамблейн 2001 оны WHA54.2 дугаар тогтоолын дагуу боловсруулсан бөгөөд нярай болон бага насны хүүхдэд зориулсан нэмэлт хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, эрүүл ахуйн шаардлага, сав, баглаа боодол болон шошгын талаарх зааварчилгааг өгсөн.

Удирдамжид тодорхойлсноор, нярай (Older infants) гэж 6-12 сартай хүүхдийг, бага насны хүүхэд (Young children) гэж 1-3 насны хүүхдийг ойлгоно гэж тодорхойлжээ. Удирдамжид зааснаар нярай болон бага насны хүүхдэд зориулсан нэмэлт хоол тэжээлийн шошгод дараах мэдээллийг тусгах ёстой гэж заасан. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүний нэр;
- Орц, найрлагын жагсаалт;
- Шим тэжээлийн талаарх мэдээлэл;
- Хэрэглэх заавар;
- Нэмэлт мэдээлэл.

[11] http://files.foodmate.com/2013/files_1193.html

[12] https://www.fao.org/fao-who-codexalimentarius/sh-proxy/en/?lnk=1&url=https%253A%252F%252Fworkspace.fao.org%252Fsites%252Fcodex%252FStandards%252FCXS%2B212-1999%252FCXS_212e.pdf

Шошго дээрх шим тэжээлийн талаарх мэдээлэл нь илчлэгийг килокалори ба киложоул (kilojoules)-аар, ууураг, нүүрс ус, өөх тосны хэмжээг граммаар илэрхийлсэн байх бөгөөд үндэсний хууль тогтоомжид заасан шим тэжээлийн бусад мэдээллээс гадна нэмсэн витамин, эрдэс бодис зэрэг нэмэлт орцны нийт хэмжээ, хэмжигдэхүүнийг тусгасан байна.

Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоолны дэглэмийн тусгай хэрэглээнд хэрэглэх шим тэжээлийн нэгдлүүдийн талаарх зөвлөмжийн жагсаалт (Advisory Lists of Nutrient Compounds for Use in Foods for Special Dietary Uses intended for Infants and Young Children)

Энэхүү зөвлөмжөөр нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоолны тусгай зориулалтын хүнсний бүтээгдэхүүнд шим тэжээлийн зориулалтаар ашиглаж болох шим тэжээлийн нэгдлүүдийн жагсаалтыг баталсан.

Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүнд ашиглах шим тэжээлийн нэгдлүүдийн шалгуурын энэ зөвлөмжид заасан бөгөөд тэдгээр шаардлага хангаагүй бол жагсаалтаас хасч болно. Харин жагсаалтад шим тэжээлийн нэгдлийг нэмэх шаардлагатай гэж үзвэл, санал гаргагч нь энэхүү зөвлөмжид заасан шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаарх мэдээллийг өгөх ёстой гэж заасан.

Нярай болон бага насны хүүхдэд зориулан боловсруулсан үр тариand суурилсан хүнсний стандарт (Standard for Processed Cereal-Based Foods for Infants and Young Children)**:** Энэхүү стандарт нь нярайн хоол тэжээлийн хэрэгцээг харгалзан 6 сартайгаас эхлэн нэмэлт хоол, бага насны хүүхдийг хооллоход зориулан боловсруулсан үр тариand суурилсан хоолны стандартыг тогтоож өгсөн. Тухайлбал, сүү болон бусад зохих тэжээллэг шингэнтэй хамт хэрэглэхээр бэлтгэсэн буюу бэлтгэх ёстой үр тарианаас бүрдсэн бүтээгдэхүүн, ус болон бусад зохих уураггүй шингэнээр бэлтгэсэн буюу бэлтгэх ёстой уураг ихтэй хүнсний бүтээгдэхүүн, буцалж буй ус болон бусад тохирох шингэнд жигнэсний дараа хэрэглэх гоймон, шууд, эсхүл нунтагласны дараа ус, сүү болон бусад тохиромжтой шингэн нэмсэн шар буурцаг, жигнэмэг гэсэн 4 ангиллын бүтээгдэхүүнд агуулагдах илчлэг, ууураг, нүүрс ус, липидүүд, эрдэс бодисууд, витаминууд, заавал байх найрлагууд, амт, чанарын үзүүлэлтүүд, нэгдсэн болон хэсгийн хэмжээ, тусгайлан хориглох заалтуудын талаар заавал тусгахаар заасан.

Чихрийн стандарт (Standard for Sugars): Энэхүү стандартаар хэрэглэгчдэд шууд худалдан борлуулдаг чихэр, хүнсний бүтээгдэхүүний орц болох 13 төрлийн чихрийг тодорхойлсон. Тухайлбал, цагаан сахар гэж 99.7-оос доошгүй хэмд цэвэршүүлж, талстжуулсан сахарозыг хэлнэ гэжээ.

Тус стандартад урьдчилан савласан хүнсний бүтээгдэхүүний стандарт (CXS 1-1985)-ын ерөнхий шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг тавьсан. Үүнд:

- Чихэр нь тус стандартад заасан тодорхойлолттой нийцэж байх ёстой бөгөөд глюкозын сироп нь 5 хувиас дээш фруктоз агуулсан бол түүнийг тусгасан тайлбарыг агуулсан байх ёстой.
- Найрлагын жагсаалтад цардуул байгаа эсэх, чихрийн агуулагдах нийт хэмжээ, нунтаг декстрозын талаар шошго, эсхүл саван дээр зааж өгсөн байхаар тус тус заасан.

2.3.Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж

ДЭМБ-аас “Насанд хүрэгчид болон хүүхдүүдийн чихрийн хэрэглээ”-ний талаарх удирдамжийг 2015 онд гаргасан. Удирдамжид дурдсанаар “чихэр” гэх нэр томьёог 1989 онд

ДЭМБ-ын судалгааны хэсгээс анх тогтоосон бөгөөд 2002 онд ДЭМБ, ХХААБ-ын хоол хүнс, хоол тэжээл, архаг өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлаарх мэргэжилтнүүдийн хамтарсан зөвлөлдөх уулзалтаар “Хүн амын шим тэжээлийн хэрэглээний зорилтууд”-ыг шинэчлэн батлахад энэ нэр томьёог ашиглажээ.

Чихэр гэдэгт үйлдвэрлэгч, тогооч, хэрэглэгчээс хүнс, ундаанд нэмдэг моносахар, дисахар, зөгийн бал, сироп, жимсний шүүс, жимсний шүүсний баяжмалд агуулагдах чихрийг хамааруулахаар тодорхойлжээ[13].

Харин насны тодорхойлолтын хувьд, 5 хүртэлх насыг бага насны хүүхэд, 5-19 насыг сургуулийн насны хүүхэд, өсвөр үед, 20-оос дээш насныхныг насанд хүрэгчдэд хамааруулсан байна.

ДЭМБ-аас өдөрт авах чихрийн нийт хэмжээ нь илчлэгийн 10 хувиас доош байх тохиолдолд илүүдэл жин, таргалалт, шүд цоорох өвчлөлийн эрсдэл буурдаг талаар мэдээлж, цаашид 7-8 хувьд хүргэхийг зөвлөж байна. Энэ нь зургаан халбага буюу 25 гр чихэртэй дүйцэх хэмжээ юм. Мөн бага насны хүүхдийн чихрийн зохистой хэрэглээг тодорхойлсон зөвлөмжийн дагуу 12 сараас доош насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүнд чихрийг хориглох бодлого баримтлахыг зөвлөж байна.

Чихэр нь хоол хүнсний нийт илчлэгийн хувийн жинд нөлөөлж, эерэг энергийн тэнцвэрийг бий болгодог бөгөөд илчлэгийн тэнцвэрийг хадгалах нь биеийн жинг хэвийн байлгах, шим тэжээлийн зохистой хэрэглээг хангахад чухал үүрэгтэй юм.

ДЭМБ-ын зааварт шинэхэн жимс, хүнсний ногооны чихэр, сүүнд агуулагдах чихрийн агууламж нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн тухай нотолгоо байхгүй байна. Өнөөдөр хэрэглэж буй чихрийн ихэнх нь чихэр шиг харагддаггүй бөгөөд боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнд “далд” хэлбэрээр байдаг. Жишээлбэл, 1 халбага кетчуп нь ойролцоогоор 4 грамм чихэр агуулж байдаг.

Дэлхий нийтээр чихрийн хэрэглээ нь нас, амьдрах орчин, улс орноос хамаарч өөр өөр байна. Европын зарим улсад насанд хүрэгчдийн хэрэглээ Унгар, Норвеги зэрэг орнуудад нийт илчлэгийн 7-8%, Испани, Их Британи зэрэг орнуудад 16-17% хооронд хэлбэлздэг. Дани, Словени, Швед зэрэг орнуудад хүүхдийн хэрэглээ 12%, Португалд бараг 25% хүртэл байдаг. Хөдөө, хотын ялгаа бас бий. Өмнөд Африкийн хөдөө орон нутагт 7.5%, хотын хүн амд 10.3% байна.

ДЭМБ-аас чихрийн хэрэглээний талаар дараах зөвлөмжийг гаргасан. Үүнд:

- Хүн төрөлхтөн амьдралынхаа туршид чихрийн хэрэглээгээ багасгахыг зөвлөж байна.
- Насанд хүрэгчид болон хүүхдийн аль аль нь чихрийн хэрэглээгээ нийт илчлэгийн 10%-аас доош хэмжээнд хүртэл бууруулахыг зөвлөж байна.
- Цаашид чихрийн хэрэглээгээ нийт илчлэгийн 5%-аас доош бууруулахыг санал болгож байна.

Мөн түүнчлэн хүүхдийн тэжээл дэх чихрийн агууламжийг хязгаарлаж, эцэг, эхчүүд хүүхдүүдийн хоолонд хүнсний ногоо ахиу хэрэглэх хэрэгтэй гэж Их Британийн Хүүхдийн эрүүл мэндийн коллежийн мэргэжилтнүүд зөвлөж байна. “Чихрийн агууламжгүй” гэх шошготой хүүхдийн тэжээлүүдэд ч мөн зөгийн бал болон жимсний шүүсний чихэр агуулагдсан байдаг бөгөөд хүүхдэд зориулсан хоол тэжээлүүдийг ихэвчлэн чихэр ихтэй жимс, хүнсний ногоогоор хийж байгаа нь асуудал дагуулж байна. Мөн савласан тэжээлүүдэд чихрийн агууламж маш өндөр байдгийг анхаарах нь чухал юм.

[13] https://www.who.int/publications/i/item/9789241549028 Guideline:Sugars intake for adults and children

ГУРАВ.ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШОШГЫН СТАНДАРТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

3.1.Европын Холбоо

Европын холбооны парламент, Европын комиссоос хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүн, түүний дотор чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгод тавигдах шаардлага, стандартын талаар дараах дүрэм, журам, зааврууды[14] батлан гишүүн орнуудын хэмжээнд мөрдүүлж байна. Үүнд:

- **Хэрэглэгчийг хүнсний бүтээгдэхүүний мэдээллээр хангах тухай дүрэм** (The provision of food information to consumers, Regulation (EU) No 1169/2011)[15];
- **Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоол тэжээл, эмнэлгийн тусгай зориулалтын хоол хүнсний тухай тусгай дүрэм** (Food intended for infants and young children, food for special medical purposes, Regulation (EU) No 609/2013)[16];
- **Нялхсын хоол тэжээл, нэмэлт тэжээлд тавигдах тусгай найрлага, мэдээллийн шаардлага, нярай болон бага насны хүүхдийн хооллолттой холбоотой мэдээллийн шаардлагын талаарх нэмэлт дүрэм** (The specific compositional and information requirements for infant formula and follow-on formula and as regards requirements on information relating to infant and young child feeding, Regulation (EU) 2016/127)[17];
- **Хүнсний нэмэлтийн тухай дүрэм** (Food additives Regulation (EC) no 1333/2008)[18].

Хэрэглэгчийг хүнсний бүтээгдэхүүний мэдээллээр хангах тухай дүрэм (The provision of food information to consumers, Regulation (EU) No 1169/2011)[19]

Тус дүрмээр хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага, тэжээллэг чанар, илчлэг, харшил төрүүлэгч, хадгалах хугацаа, гарал үүсэл зэрэг тухайн бүтээгдэхүүний талаарх иж бүрэн мэдээллийг үнэн зөв, бодит, энгийн ойлгомжтой байдлаар хэрэглэгчдэд хүргэх харилцааг зохицуулсан.

Түүнчлэн дүрэмд хүнсний бүтээгдэхүүний орц, найрлагатай холбоотой мэдээллийг бүтээгдэхүүний сав баглаа боодол, зар сурталчилгаа, сурталчилгааны материал дээр тодорхой, хялбар байдлаар илэрхийлэх шаардлага, шалгуурыг тогтоосон.

Цаашилбал, савласан хүнсний бүтээгдэхүүний шошгод шим тэжээлийн талаарх мэдээллийг илчлэг, өөх тос, ханасан өөх тос, нүүрс ус, **чихэр**, уураг, давсны хэмжээг багтаасан мэдээллийг стандарт хэлбэрт оруулахаар уг дүрэмд тусгасан. Ерөнхийдөө уг дүрэм нь хэрэглэгч худалдан авсан хүснийхээ талаар тодорхой, үнэн зөв, бодит мэдээлэл олж авч хооллолтынхоо дэглэмийн талаар зүй зохистой шийдвэр гаргахад нь хэрэглэгчдийг мэдээллээр хангах, эрүүл хүнсний сонголтыг дэмжих зорилготой юм.

---

[14] Food labelling for Consumers: EU Law, Regulation and Policy options, 2019: https://sante.gouv.fr/IMG/pdf/food_labelling_for_consumer_eu.pdf

[15] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:02011R1169-20180101

[16] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32013R0609

[17] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32016R0127

[18] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:02008R1333-20200702#tocId49

[19] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:02011R1169-20180101

Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоол тэжээл, эмнэлгийн тусгай зориулалтын хоол хүнсний тухай дүрэм (Food intended for infants and young children, food for special medical purposes, Regulation (EU) No 609/2013)[20]

Энэхүү дүрэм нь нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоол тэжээл, эмнэлгийн тусгай зориулалтын хоол хүнс нь аюулгүй, тохиромжтой, зохистой байх хэрэглэгчид тэдгээр бүтээгдэхүүний шошго дээрээс тухайн бүтээгдэхүүний талаар тодорхой, иж бүрэн, үнэн зөв мэдээлэл авах боломжийг хангах зорилготой юм. Тус дүрэмд нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага болон тэдгээр бүтээгдэхүүний шошго дээр зайлшгүй тавигдах шаардлагыг тогтоосон бөгөөд тухайн шим тэжээл нь зорилтот насны бүлэгт тохирсон, аюулгүй, тэжээллэг байх шалгуур, хэмжүүрийг заасан байдаг. Үүнд: Тухайн хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүн нь ямар насны ангилалд тохирох, түүнд агуулагдах тэжээллэгийн онцлог, хэрэглэх заавар түүнчлэн зарим орц найрлага, хүнсний нэмэлтүүдийн хэрэглээг хязгаарлах заалтууд зэрэг шошгод заавал тавигдах шаардлагууд багтана.

Нялхсын хоол тэжээл, нэмэлт тэжээлд тавигдах тусгай найрлага, мэдээллийн шаардлага, нярай болон бага насны хүүхдийн хооллолттой холбоотой мэдээллийн шаардлагын талаарх нэмэлт дүрэм (The specific compositional and information requirements for infant formula and follow-on formula and as regards requirements on information relating to infant and young child feeding, Regulation (EU) 2016/127, Regulation (EU) No 609/2013)[21]

Тус дүрэмд үр тариа, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, самар, мах, загас, сүүн бүтээгдэхүүн зэрэг өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах кадмийны дээд хэмжээг тогтоож өгсөн байдаг. Эдгээр хэмжээ нь хүний эрүүл мэндэд хор учруулж болзошгүй эрсдэлийг тооцсон шинжлэх ухааны судалгаа, үнэлгээнд суурилсан байх ба хүнсний төрөл, гарал үүслээс хамаарч өөр өөр байдлаар тогтоогдсон байдаг. Кадмий нь хүний биед цаг хугацааны туршид хуримтлагдсаар эрүүл мэндэд нөхөж баршгүй хөнөөл учруулж болзошгүй хүнд, хортой металл юм.

Уг дүрэмд кадмийны дээд хэмжээг тогтоохоос гадна хүнсний бүтээгдэхүүн дэх кадмийны хэмжээг байнга хянаж, үр дүнг Европын Комисст тогтмол мэдээлэхийг гишүүн орнуудаас шаарддаг. Мөн энэхүү дүрмийг хэрэгжүүлээгүй тохиолдолд албадлагын арга хэмжээ авах, гаргасан зөрчилд хариуцлага тооцохоор тусгагдсан байна.

Хүнсний нэмэлтийн тухай дүрэм (Food additives, Regulation (EC) no 1333/2008)[22]

Тус дүрмээр бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүнд хүнсний нэмэлт ашиглах, хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг. **Хүнсний нэмэлт** (Food additives) гэдэг нь хүнсний бүтээгдэхүүнд өнгө оруулах, үнэр, амтыг сайжруулах, хэлбэр, бүтцийг хэвшүүлэх, хадгалах хугацааг уртасгах зэрэг зорилгоор нэмдэг тусгай бодис юм. Дүрэмд Европын холбооны хэмжээнд хэрэглэхийг зөвшөөрсөн хүнсний нэмэлтүүдийн жагсаалт болон тэдгээрийн ашиглалтын нөхцөл, зөвшөөрөгдөх дээд хэмжээ зэргийг тогтоодог. Уг жагсаалтад 300 гаруй хүнсний нэмэлт багтдаг боловч шинжлэх ухааны шинэ үндэслэл, нотолгоо, хүнс боловсруулалтын салбарын практик өөрчлөлттэй уялдуулан тогтмол шинэчилдэг байна. Уг дүрэмд зааснаар хүнсний нэмэлтийг шошго дээр нэрээр нь, эсхүл Е-тоон дугаараар нь заавал бичсэн байх ёстой.

[20] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32013R0609

[21] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32016R0127

[22] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:02008R1333-20200702#tocId49

Нэмж дурдахад, хүнсний бизнес эрхлэгчид шинээр ашиглах, хэрэглэх шаардлагатай байгаа хүнсний нэмэлтийнхээ талаар Европын хүнсний аюулгүй байдлын газарт (EFSA) заавал мэдэгдэх үүрэгтэй байдаг. Энэ байгууллага тухайн хүнсний нэмэлтийг Европын холбооны хэмжээнд ашиглаж болох эсэх зөвшөөрөл олгохоосоо өмнө аюулгүй байдлын үнэлгээ хийдэг.

Стандарт, шаардлага: Хэрэглэгчийг хүнсний бүтээгдэхүүний мэдээллээр хангах тухай дүрэм (FIC) Европын холбооны хэмжээнд 2014 оноос хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Тус дүрмийн 9 дүгээр зүйлд[23] зааснаар хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын шошгод дараах заавал биелүүлэх нийтлэг[24] шаардлагыг тавьдаг байна. Эдгээр нь:

1. **Бүтээгдэхүүний нэр**: Шошгод бүтээгдэхүүний нэр төөрөгдөл үүсгэхээргүй, эсхүл хоёрдмол утгагүйгээр үнэн зөв, тодорхой, ойлгомжтойгоор илэрхийлэгдсэн байх ёстой;
2. **Орц, найрлагын жагсаалт**: Хамгийн гол орц, найрлагыг эхэнд нь байрлуулах байдлаар жин, хэмжээний дарааллаар жагсаах бөгөөд харшил үүсгэгчийн хэрэглээг маш тодорхой зааж өгөх ёстой;
3. **Цэвэр жин**: Бүтээгдэхүүний жин хэмжээг грамм, эсхүл миллилитрээр тодорхой илэрхийлсэн байх;
4. **Хүчинтэй хугацаа**: Тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн, савласан мөн хэрэглэх, ашиглах (use-by date), эсхүл чанараа хадгалах (best-before date) зэрэг хугацааг шошгод заавал тавих ёстой;
5. **Гарал үүслийн заалт**: Тухайн бүтээгдэхүүний шошгод үйлдвэрлэсэн улс, газар орны нэрийг зааж өгөх ёстой. Энэ мэдээлэл нь хэрэглэгчийн сонголтод нөлөөлөх магадлалтай гэж үздэг;
6. **Тэжээллэгийн мэдээлэл**: Шошго нь тухайн бүтээгдэхүүнд агуулагдах өөх тос, ханасан өөх тос, нүүрс ус, **чихэр**, уураг, давсны хэмжээ мөн нийт илчлэг, чийглэг зэрэг мэдээллийг агуулсан байх ёстой. Ингэхдээ 100 гр, эсхүл 100 мл-д агуулагдах хувийн жингээр илэрхийлнэ;
7. **Харшил төрүүлэгчийн мэдээлэл**; Үндсэн 14 харшил төрүүлэгчийн аль нэг нь тухайн бүтээгдэхүүнд байж болох, эсхүл байгаа эсэхийг шошгод тодорхой зааж өгөх ёстой;
8. **Нэмэлт мэдээлэл**: Шошгод тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэх, ашиглах заавар, хадгалах нөхцөл, дахин боловсруулах (recycling) зөвлөмж зэрэг нэмэлт мэдээллийг тусгаж болно.

Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоол тэжээл, эмнэлгийн тусгай зориулалтын хоол хүнсний тухай дүрмийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн[25] (a), (b)-д “**Нярай** (Infant) гэж 0-12 сар хүртэлх, **бага насны хүүхэд** (Young child) гэж 01-ээс 3 хүртэлх настай хүүхдийг ойлгоно гэж тус тус заасан.

Дээр дурдсан нийтлэг шаардлагаас гадна нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүн, түүний дотор чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгод дараах **тусгай шаардлага**[26] тавигддаг. Үүнд:

- **Чихрийн агууламжийн мэдэгдэл**: Хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод түүнд агуулагдах чихрийн хэмжээг заавал бичсэн байх ёстой. Ингэхдээ 100

[23] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:02011R1169-20180101

[24] https://europa.eu/youreurope/business/product-requirements/food-labelling/general-rules/index_en.htm

[25] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32013R0609

[26] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32013R0609

грамм тутамд ногдох граммаар, эсхүл хувь хэмжээгээр уншихад хялбар, тод харагдахуйц байдлаар илэрхийлсэн байх;

- **Насанд нь тохируулан хэрэглэх хэмжээ** (serving size): Шошго дээр заагдсан хэмжээ нь тухайн насны хүүхдэд тохируулан хэрэглэх хэмжээг заасан байх ёстой. Насанд хүрсэн хүнд тохирох хэмжээнээс бага байхаар зааж өгнө. Ингэхдээ хүүхдийн нас, насны онцлогт тохирсон байдлаар хэрэглэх хэмжээг шошгод тодорхой тусгасан байвал зохино;
- **Энгийн ойлгомжтой хэллэг ба дүрслэл**: Тухайн бүтээгдэхүүний шошго нь хүүхдэд ойлгогдох үг хэллэгээр бичигдсэн, энгийн хялбар зураг, дүрслэл ашигласан байх ёстой. Үүнд: чихрийн агууламжийг дүрслэн харуулахын тулд зураг, тэмдэгт ашиглах, тодорхой бөгөөд товч хэллэг ашиглах зэрэг байж болно;
- **Эрүүл мэндийн хамаарлын заалт**: Хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод "чихэр багатай" (low in sugar), эсхүл "чихрийг нь багасгасан" (reduced sugar) гэх мэт чихрийн агууламжийн талаар эрүүл мэндтэй холбоотой ямар нэгэн заалт оруулж болохгүй. Ялангуяа 3-аас доош насны хүүхдэд зориулсан бүтээгдэхүүнд ийм заалтыг огт зөвшөөрдөггүй;
- **Харшил төрүүлэгчийн мэдээлэл**: Бүтээгдэхүүн нь самар, цагаан идээ зэрэг хүүхдэд харшлын урвал үүсгэж болзошгүй бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байвал шошго дээр тодорхой бичсэн байх ёстой.

Хүнсний нэмэлтийн тухай дүрмийн 16 дугаар зүйлд[27] “тусгайлан зааснаас бусад тохиолдолд хүнсний нэмэлтийг нярай болон бага насны хүүхдийн хоол тэжээлд хэрэглэхийг хориглоно” гэж заасан байдаг. Үүнд нэмэлт чихэр ч мөн хамаарна.

Зураг 2. Европын холбооны хүнсний бүтээгдэхүүний шошгын төрөл, стандарт



[27] https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:02008R1333-20200702#tocId49

3.2.Австрали, Шинэ Зеланд Улс[28]

Австрали-Шинэ Зеланд Улс нь савласан хүнсний бүтээгдэхүүнд заавал шим тэжээлийн шошго (nutrition labelling) тавихыг шаарддаг улс орнуудын нэг юм. Австрали-Шинэ Зеландын бүх муж, нутаг дэвсгэрийн хүнсний стандартыг хангах зорилгоор Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 1991 онд байгуулж, “Австрали, Шинэ Зеландын Хүнсний стандартын хууль”-ийг баталжээ. Уг хуулиар хүнсний стандартын хэрэгжилтийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, савласан хүнсний бүтээгдэхүүний шошгод заавал шим тэжээлийн мэдээлэл тавих талаар хуульчилсан байна.

Дээрх хуулийн дагуу байгуулагдсан Австрали-Шинэ Зеландын Хүнсний стандартын байгууллагаас (FSANZ) 2000 онд Хүнсний стандартын дүрмийг (Food Standards Code) [29] боловсруулж, 2002 оноос албан ёсоор бүх хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагчдад зориулсан заавал байх ёстой хүнсний нэмэлт, шошгын стандартаас гадна үйлдвэрлэлийн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтад тавигдах шаардлагыг тогтоожээ. Тус дүрмийн 2 дугаар бүлэгт хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний чихрийн агууламж, шошгын стандартын талаар зохицуулсан байдаг.

Австрали-Шинэ Зеландын хүнсний зохицуулалтын байгууллагууд хүнсний стандартыг хэрэгжүүлж, мөрдүүлэхийн тулд нягт хамтран ажилладаг бөгөөд Хүнсний зохицуулалтын хэрэгжилтийн дэд хороо (Subcommittee for Food Regulation (ISFR))[30] болон Хүнсний зохицуулалтын Байнгын хороо (Food Regulation Standing Committee-FRSC)[31], түүний дэд хороодоор дамжуулан хэрэгжүүлж, хяналт тавьдаг байна.

Хүүхдийн хүнсний чихрийн агууламж, баримталж буй бодлого

Австрали-Шинэ Зеландын хүнсний стандартыг хэрэгжүүлэх бодлогын гол арга хэмжээ нь таргалалтыг бууруулах, чихрийн хэрэглээг багасгах, хэрэглэгчдэд хүнсний зөв сонголт хийх боломжийг олгох явдал юм. Энэ арга хэмжээний хүрээнд дараах бодлогын баримт бичиг, удирдамжуудыг боловсруулан хэрэгжүүлжээ. Тухайлбал,

- “Савласан хүнсний бүтээгдэхүүн болон ундааны чихрийн үзүүлэлтийн талаарх мэдээлэл” бодлогын баримт бичиг (Labelling of sugars on packaged foods and drinks);
- Австралийн хоолны дэглэм ба нярай хүүхдийн хооллолтын удирдамж (Australian Dietary Guidelines and the Infant Feeding Guidelines)
- Шинэ Зеландын нярай болон бага насны хүүхдийн хооллолтын удирдамж (0-2 нас) (Eating for Health Babies and Toddlers);
- Хэрэглэгчдэд эрүүл сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх хүнсний шошгын талаар баримтлах бодлогын удирдамж зэрэг болно.

Австрали-Шинэ Зеландын хүүхдийн хооллолтын удирдамжуудад бага насны хүүхдэд (0-2 нас) чихрийн агууламж бүхий хоол тэжээл өгөхөөс татгалзахыг зөвлөсөн. Мөн хэрэглэгчдэд болон эцэг, эхчүүдэд аливаа хүнсний бүтээгдэхүүний чихрийн орц, найрлагын шошгон дээрх мэдээллийг зөв уншиж, сонголтоо хийхийг зөвлөдөг байна. Эдгээр эрүүл

[28] https://www.foodstandards.gov.au/Pages/default.aspx

[29] https://www.foodstandards.gov.au/code/Pages/default.aspx

[30] https://foodregulation.gov.au/internet/fr/publishing.nsf/Content/ISFR

[31] https://foodregulation.gov.au/internet/fr/publishing.nsf/Content/FRSC

хооллолтын удирдамжийг тууштай хэрэгжүүлэх зорилгоор Хүнсний зохицуулалтын байнгын хороо (Food Regulation Standing Committee-FRSC)-ноос 2019 онд “Савласан хүнсний бүтээгдэхүүн болон ундааны чихрийн үзүүлэлтийн талаарх мэдээлэл” бодлогын баримт бичгийг[32] боловсруулсан. Тус бодлогын баримт бичигт хүнсний бүтээгдэхүүний чихрийн агууламж, орц найрлагын мэдлэг олгох, чихрийн агууламж бүхий орц найрлагыг тодорхойлох, чихэр ихтэй бүтээгдэхүүнийг ялгаж таних тэмдэглэгээ, шошгын талаар тусгажээ. Бодлогын баримт бичиг нь Хүнсний стандартын дүрмийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэглэгчдэд мэдээлэлтэй сонголт хийх, хоол хүнсний хортой чихрийн эх үүсвэрийг хянах боломжийг олгодог.

Хүнсний бүтээгдэхүүний шошгын стандартад Эрүүл мэндийн Одны Үнэлгээний (HSR) системийг ашигладаг. Энэ нь Австрали-Шинэ Зеландын Засгийн газруудаас дэмжигдсэн сайн дурын үндсэн дээр шошголох систем бөгөөд савласан хүнсний бүтээгдэхүүний нийт шим тэжээлийн үзүүлэлтийг үнэлж, 0.5-5 хүртэлх одоор үнэлгээ өгдөг. Элсэн чихрийн нийт агууламжийг HSR графикийн хэсэг болгон шим тэжээлийн үзүүлэлтэд харуулж болно. Хэдийгээр бага насны хүүхдийн хоол хүнсний шошгонд HSR системийг ашиглах ёсгүй ч 12 сараас дээш насны хүүхдэд зориулсан зарим хүнсний бүтээгдэхүүний чихрийн агууламжийг тодорхойлоход хэрэглэдэг байна.

Хэрэглэгчдэд хүнсний шошгын стандартыг хэрэгжүүлэх, эрүүл зөв сонголтыг хийхэд туслах зорилгоор “Хэрэглэгчдэд хүнсний зөв сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх гарын авлага”-ыг боловсруулсан. Энэ нь хэрэглэгчдэд шошгын стандартад хяналт тавих, хүнсний аюулгүй хэрэглээ, эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүнийг сонгон авахад чухал дэмжлэг болдог байна.

Хууль, эрх зүйн орчин

Австрали-Шинэ Зеландад бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгын стандартыг зохицуулсан бие даасан хууль байхгүй. Харин хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн үзүүлэлт, шошгын стандартын талаар дараах хууль, дүрмээр зохицуулжээ. Тухайлбал,

- Австрали-Шинэ Зеландын Хүнсний стандартын хууль (1991)
- Австрали-Шинэ Зеландын Хүнсний стандартын дүрэм (2000)

Хүнсний стандартын тухай хууль нь хүнсний аюулгүй байдал, шошгололт, найрлага, хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах талуудад тавигдах шаардлагууд зэрэг ерөнхий хүрээг хамардаг.

Хүнсний стандартын дүрэм нь бүх хүнсний бүтээгдэхүүний орц найрлага, шошгын стандарт, хүнсний аюулгүй байдал, тавигдах шаардлагуудыг нарийвчлан тогтоосон байдаг.

Бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгын стандартын талаар Хүнсний стандартын дүрэмд тусгайлан зохицуулсан байна.

Австрали - Шинэ Зеландын хүнсний стандартын дүрэм[33] (Australia New Zealand Food Standarts Code): Тус стандарт нь Австрали-Шинэ Зеландын хүнсний аюулгүй байдал, хүнсний зөв хэрэглээг нэвтрүүлэх, хүнсний стандартын хэрэгжилтийн тэгш байдлыг хангах зорилготой. Стандартын 1 ба 2-р бүлэг нь Австрали болон Шинэ Зеландын аль алинд нь үйлчилнэ. Харин 3 ба 4-р бүлэг нь зөвхөн Австрали Улсад үйлчилнэ. Хүнсний стандарт нь үндсэн 4 бүлэгтэй:

[32] https://www.foodstandards.gov.au/consumer/labelling/Documents/Review%20of%20nutrition%20labelling%20for%20added%20sugars.pdf

[33] Food standarts code https://www.foodstandards.gov.au/code/pages/default.aspx

1-р бүлэг - Хүнсний ерөнхий стандарт: Энэ бүлэгт бүх хүнсний бүтээгдэхүүнд хамаарах ерөнхий стандартыг зохицуулсан бөгөөд шошго, хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага, микробиологийн хязгаарлалт, генийн өөрчлөлттэй болон цацраг идэвхт хүнсний бүтээгдэхүүний зохицуулалт зэрэг орно.

2-р бүлэг - Хүнсний бүтээгдэхүүний стандарт: Энэ бүлэгт тодорхой хоол хүнс болон хүнсний ангилалд хамаарах тодорхойлолт, найрлага, шошгын шаардлагыг багтаасан болно.

3-р бүлэг - Хүнсний аюулгүй байдлын стандарт: Эдгээр стандартууд нь хүнсний бүх бизнест хамаарах бөгөөд хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах бүх талууд болон хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд тавигдах шаардлагыг тогтоодог. Стандартууд нь Виктория дахь орон нутгийн засаг захиргааны хүрээлэн буй орчны эрүүл мэндийн эмч нарын хэрэгжүүлэх үйл ажиллагааг голлон зохицуулсан байдаг.

4-р бүлэг - Үйлдвэрлэл, боловсруулалтын үндсэн стандарт: Энэ бүлэгт далайн бүтээгдэхүүн, мах, шувууны мах, сүүн бүтээгдэхүүн, тусгай бяслаг, өндөг, үрийн нахиа, жимс, жимсгэнэ, дарсны анхан шатны үйлдвэрлэл, боловсруулалтын стандартыг багтаасан болно.

Хүнсний стандартын дүрмийн 2.8-2.9-р бүлгийн агуулгыг дэлгэрэнгүй авч үзвэл:

Бүлэг 2.8 Элсэн чихэр ба зөгийн бал

Стандарт 2.8.1 Элсэн чихэр ба чихэрлэг бүтээгдэхүүн (Sugar and sugar products)

Стандарт 2.8.2 Зөгийн бал

Бүлэг 2.9 Бусад хүнсний онцгой бүтээгдэхүүнүүд

Стандарт 2.9.1 Нярай хүүхдийн сүүн бүтээгдэхүүн

Стандарт 2.9.2 Нярай хүүхдийн хоол тэжээл

Стандарт 2.9.3 Боловсруулсан хүнсний орлуулагч болон боловсруулсан нэмэлт хүнс

Стандарт 2.9.4 Спортын нэмэлт боловсруулсан хүнс

Стандарт 2.9.5 Эрүүл мэндийн тусгай зориулалтын хүнс

Стандарт 2.9.6 Тусгай зориулалтын хүнсний түр буюу шилжилтийн стандарт (амин хүчлийг өөрчилсөн хүнсийг оруулаад)

Бүлэг 2.10 Бусад хүнсний стандартууд зэрэг болно.

Хүнсний бүтээгдэхүүний шошгын ерөнхий стандарт

Австрали-Шинэ Зеландын Шударга өрсөлдөөний хууль болон хүнсний хуулиуд нь шошгоор дамжуулан худал эсхүл хууран мэхлэх замаар хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөхгүй байхыг шаарддаг бөгөөд хүнсний бүтээгдэхүүний шошгод тавигдах шаардлагыг Хүнсний стандартаар тогтоосон. Хүнсний стандартын дүрмийн 1.2.1-д хүнсний бүтээгдэхүүний шошгод тавигдах шаардлагыг тодорхойлсон бөгөөд шошго нь тухайн бүтээгдэхүүний жинхэнэ мөн чанарыг тодорхойлох үнэн зөв нэр эсхүл тайлбартай байх ёстойгоос гадна бүтээгдэхүүний арын хэсэгт багцанд агуулагдах шим тэжээлийн үзүүлэлтийг багтаасан байх ёстой.

Шошго нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Хүнсний нэр;
- Багцыг тодорхойлох;
- Нийлүүлэгчийн нэр, хаяг;
- Анхааруулга, зөвлөмжийн мэдэгдэл;
- Орц, найрлагын мэдэгдэл;
- Огнооны тэмдэглэгээ;
- Хадгалах нөхцөл, ашиглах заавар;
- Хоол тэжээл, эрүүл мэнд болон холбогдох бусад мэдээлэл;

- Шим тэжээлийн үзүүлэлт (NIP);
- Хүнсний гарал үүслийн талаарх мэдээллийг заавал агуулсан байх бөгөөд гаргацтай, тод, англи хэл дээр байх ёстой.

Шим тэжээллийн үзүүлэлт нь савласан бүтээгдэхүүний ар талын хэсэгт байх ба үүнд хүнсэнд агуулагдаж буй илчлэг, ууураг, өөх, тос, нүүрс ус, чихэр, давс, шим тэжээлийн талаарх бусад шаардлагатай мэдээллүүдийг бүрэн дэлгэрэнгүй бичсэн байна. Энэ мэдээлэл нь шингэн бол 100 мл, хатуу бүтэцтэй хүнс бол 100 граммаар хэрхэн хэрэглэхийг заасан байна.

Анхааруулгад заасан мэдээллийн хэмжээ нь жижиг савлагаатай бол 1.5 мм, бусад тохиолдолд 3 мм-ээс багагүй өндөртэй байна.

Хүнсний бүтээгдэхүүний чихрийн агууламж, шошгын стандарт

Австрали-Шинэ Зеландын хоолны дэглэмийн удирдамжид (Dietary guidelines in both Australia and New Zealand (NHMRC, 2013)) ханасан өөх тос, нэмсэн давс, нэмсэн элсэн чихэр, согтууруулах ундаа агуулсан хүнсний хэрэглээг хязгаарлахыг заасан. Насанд хүрсэн хүний өдөрт хэрэглэх чихрийн хэмжээг 90 гр байхаар Хүнсний стандартад тогтоосон бөгөөд "элсэн чихэр багатай" хоол хүнс нь 100 мл шингэн хүнсэнд 2.5 гр-аас илүүгүй эсхүл 100 грамм хатуу хүнсэнд 5 гр-аас илүүгүй байх ёстой байдаг.[34]

Хүнсний стандартын дүрмийн 1.2.8-д шошголох шаардлагатай худалдаалагдах хүнсний бүтээгдэхүүний шошгын шаардлагыг тодорхойлсон. Тухайлбал, Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгон дээр орц найрлага, шим тэжээлийн үзүүлэлт, агууламжийн мэдээлэл (content claims) зэрэг шим тэжээлийн мэдээллийг багтаасан байх ёстой.

Хүнсний стандартад элсэн чихрийн орц найрлагыг тус тусынх нь тодорхой нэрийг зааж оруулна гэсэн байдаг. Харин шим тэжээлийн үзүүлэлтэд элсэн чихрийг “нүүрс усны” нэг хэсэг болгон оруулахаас гадна “элсэн чихэр” гэж нэрлэж тусад нь жагсааж бичнэ.

Орц найрлагын жагсаалтад орсон чихэр гэдэг нь зөвхөн тухайн бүтээгдэхүүнд нэмж оруулсан орц юм. Шим тэжээлийн үзүүлэлт дэх “чихэр” гэдэг нь бүх чихэрлэгийг илэрхийлнэ: – үүнд жимс, жимсгэнэд агуулагдах байгалийн чихэр, үйлдвэрлэлийн явцад найрлагад нэмсэн чихэр зэргийг оруулдаг.

Хүнсний стандартад зааснаар “чихэр” гэсэн нэрийг: цагаан элсэн чихэр, сайжруулсан цагаан элсэн чихэр, сахрын нунтагууд, ёотон, мөсөн чихэр, кофены чихэр, кофены талстууд, түүхий элсэн чихэр зэргийг тодорхойлоход хэрэглэнэ.

Орц найрлагын мэдээлэлд “чихэр” гэх нэрийг ашиглаж болохгүй. Зөвхөн тодорхой чихэр амттаныг “чихэр” гэж жагсаалтад оруулах тул бусад нэмэлт төрлийн чихэр амтлагчдыг “орц, найрлагын чанараар нь тодорхойлсон нэр”-ийг хэрэглэнэ. Тухайлбал, нишингийн чихэр, цагаан элсэн чихэр, жимсний шүүс, бор элсэн чихэр, глюкозын сироп, фруктоз, лактоз гэх мэт.

Орц найрлагын жагсаалтад бүх орцыг жин хэмжээнийх нь дагуу жагсаана. Ингэхдээ орц найрлагад хамгийн их хэмжээтэй орсон орцоос эхлэн хамгийн бага хэмжээтэй орц найрлага хүртэл буурах дарааллаар бичнэ.

Мөн Хүнсний стандартын дүрмийн 1.2.7-д хүнсний шимт бодисын агууламжийн мэдээлэл (content claims) болон эрүүл мэндийн мэдээллийн (health claims) талаар зохицуулсан бөгөөд эрүүл мэндийн мэдээллийг шинжлэх ухааны нотолгоогоор батлах ёстой. Зөвхөн шим тэжээлийн үзүүлэлтийн шалгуурыг хангасан хүнсний бүтээгдэхүүнд

[34] https://www.foodstandards.gov.au/consumer/labelling/Pages/Sugar-labelling.aspx

эрүүл мэндийн мэдээлэл гаргахыг зөвшөөрдөг. Харин ханасан өөх тос, элсэн чихэр, давс ихтэй хоол хүнсэнд эрүүл мэндийн мэдээлэл гаргахыг зөвшөөрдөггүй.

Чихрийн агууламжийг тодорхойлох шошгын бас нэгэн стандарт нь Эрүүл мэндийн одны үнэлгээний систем[35] (HSR) юм. Уг системийг ус, ундаанд дараах байдлаар хэрэглэнэ.

- энгийн ус - 5 одтой
- чихэргүй амттай ус – 4.5
- 100% жимс, ногооны шүүс – 2.5-аас 4 одтой (элсэн чихэр, илчлэгийн агууламжаас хамаарч)
- хоолны дэглэмийн ундаа – 3.5 одоос илүүгүй
- чихэрлэг зөөлөн ундаа – 0.5-аас 2 одтой (элсэн чихэр, илчлэгийн агууламжаас хамаарч).

Эрүүл мэндийн одны үнэлгээний тэмдэглэгээг савласан ус, ундааны нүүрэн талд тавина.[36]



Бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний чихрийн агууламж, шошгын стандарт[37]

Нярай болон бага насны хүүхдийн хооллолтын удирдамж (Eating for Health Babies and Toddlers (revised 2013))-д бага насны хүүхдийн хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүнд чихрийн агууламжийг хориглодог. Австрали-Шинэ Зеландын Хүнсний стандартын дүрмийн 2.9-д Нярай болон бага насны хүүхдэд (0-2 нас) зориулсан хоол хүнсний найрлага болон шошгын шаардлагыг тодорхойлсон байдаг.

Тус дүрэмд зааснаар нярай хүүхдэд зориулсан хоол хүнс нь найрлагын тодорхой шаардлагыг хангасан байх ёстой. Нярайн хоол хүнсэнд тавигдах тусгай найрлагад натрийн агууламжийн дээд хязгаар, үр тариа, үр тарианы бус хүнсний бүтээгдэхүүний найрлагад тавигдах тусгай шаардлага (жишээ нь, натри, төмрийн агууламж), түүнчлэн витамин, эрдэс бодисыг сайн дураар нэмэхэд тавигдах шаардлагууд, нэмэлт шошгын шаардлага зэрэг багтана.

Дүрэмд нярай гэж 12 сар хүртэлх насны хүүхэд гэж тодорхойлсон. 12 сараас дээш насны хүүхдэд зориулсан хоол хүнсний найрлагад ижил шаардлага тавьдаггүй. Гэхдээ нярай болон бага насны хүүхдийн хоол хүнсний найрлагад чихрийн агууламжийг зөвшөөрдөггүй.

Бага насны хүүхдийн хоолонд агуулагдах элсэн чихэр, зөгийн балны моносахар, дисахарын агууламж 4 г/100 гр-аас их байвал тухайн хүнсийг "чихэрлэг" гэж тодорхойлсон шошготой байх шаардлагатай. Нярай болон бага насын хүүхдэд зориулсан чихэр агуулсан бүтээгдэхүүнийг шошголоход дараах стандартыг баримтална:

---

[35] https://www.foodstandards.gov.au/consumer/labelling/Documents/Review%20of%20nutrition%20labelling%20for%20added%20sugars.pdf

[36] https://foodregulation.gov.au/internet/fr/publishing.nsf/Content/E14EAF213251596ECA25883F008204A3/$File/Food%20regulation%20website%20update%20-%20Commerc~arly%20childhood%20Australia%20and%20New%20Zealand%20-%20Background%20paper%20PDF%20-%2027%20April%202022.PDF

[37] Мөн тэнд

2.9.2-7 **Шошголох (Labelling)**

(1) Энэ нь савласан усанд хамааралгүй.
(2) Нярайн хүнсний бүтээгдэхүүний савалгаан дээрх шошгонд энэхүү хүнс нь 4 сар хүртэлх нярайд хэрэглэнэ гэснээс өөрөөр ил болон далд ямар нэг хэлбэрээр зөвлөмж бичихгүй.
(3) Шошгонд заавал орох мэдээллүүд нь:

(a) хүнсний зохицол нийцэмжийн талаарх мэдээлэл;
(b) энэхүү хүнсийг хамгийн багадаа хэдэн настай нярайд зориулсныг тоогоор илэрхийлэн бичих;
(c) хэрвээ тухайн хүнсийг 6-аас доош сартай нярайд зориулсан бол - (b) гэсэн догол мөр нэмж, *анхааруулга '6 сартайгаас бага насны нярайд зориулаагүй' гэж бичих;
(d) хэрвээ моносахар (monosaccharide) ба дисахар (disaccharide) агуулсан нэмэлт чихэр ба зөгийн балны хэмжээ 4 гр/100 гр-аас илүү бол - "чихэрлэг (sweetened)" гэж бичнэ;
(e) хэрвээ зөгийн балыг найрлага дахь орц болгож хэрэглэсэн бол - "зөгийн бал" гэдэг үгийг "ариутгасан" гэдэг үгийн хамтаар хэрэглэх гэх мэт.

2.9.1-20 Шошгын анхааруулга, мэдэгдлийн хэмжээ нь:

(a) савлагаа нь 500 гр-аас дээш цэвэр жинтэй бол - 3 мм;
(б) савлагаа нь 500 грамм ба түүнээс бага жинтэй бол - 1.5 мм байна.

2.9.1-21 Шим тэжээлийн үзүүлэлтийг дараах байдлаар тэмдэглэнэ:

(a) "уухад бэлэн" болон нунтаг, өтгөрүүлсэн сүү, сүүн бүтээгдэхүүний хувьд:
(i) *кЖ/100 мл-ээр илэрхийлсэн илчлэгийн дундаж агууламж; болон
(ii) г/100 мл-ээр илэрхийлсэн ууураг, өөх тос, нүүрс усны дундаж хэмжээ; болон
(iii) витамин, эрдэс ба бусад бодис бүрийн дундаж хэмжээ, энэ стандартаар зөвшөөрөгдсөн тэжээллэг бодис болгон ашигладаг, жин/100 мл-ээр илэрхийлсэн (байгалиас үүссэн аливаа хэмжээг оруулаад); болон
(iv) нэмсэн бол жин/100 мл-ээр илэрхийлсэн дундаж хэмжээг тус тус бичнэ.

3.3.Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг болох Хүнс болон эмийн захиргаа (Food and Drug Administration) нь үндэсний хэмжээнд үйлдвэрлэгдэн, борлуулагдаж буй хүнс, эм, гоо сайхны бүтээгдэхүүнд хяналт тавих эрх бүхий байгууллага юм. АНУ нь хүнсний аюулгүй байдлын стандартаар дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг бөгөөд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас батлан гаргасан Олон улсын хүнсний стандартыг баримтлан, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, савлагаа, хадгалалт, тээвэрлэлт болон бүтээгдэхүүний орц, найрлага шошгод тавигдах шаардлага зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

Бүтээгдэхүүний шим тэжээл, орц найрлага, бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн болон савласан газар, борлуулагчийн талаарх цогц мэдээллийг хэрэглэгчдэд үнэн зөв, хялбар, ойлгомжтой хүргэх үүднээс бүтээгдэхүүний шошгод тавигдах стандарт, шаардлагыг дараах хууль тогтоомжуудаар зохицуулдаг байна. Үүнд:

- Холбооны Хүнс, Эм, Гоо сайхны бүтээгдэхүүний тухай хуулийн IV бүлэг-Хүнс (Federal Food, Drug, and Cosmetic Act Chapter IV: Food)[38];
- Шударгаар савлах болон шошголох тухай хууль (Fair Packaging and Labeling Act of 1967)[39];

[38] http://uscode.house.gov/browse/prelim@title21/chapter9/subchapter4&edition=prelim

[39] https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-385/pdf/COMPS-385.pdf

- Шим тэжээлийн шошго болон түүний талаар мэдлэг олгох тухай хууль (Nutrition Labeling and Education Act 1990) зэрэг хуулиуд,
- Холбооны журмын 21-р бүлэг Хүнс болон эм, 101 Хүнсний шошго хэсэг (Code of Federal Regulations (CFR): Title 21 - Food and Drugs - Part 101-Food Labeling)-ээр[40] тус тус зохицуулж байна.

Холбооны журмын 21-р бүлэг Хүнс болон эм, 101 Хүнсний шошго хэсэг: Хүнсний бүтээгдэхүүний шошгод чихрийн агууламжийг хэрхэн тэмдэглэх талаар зохицуулсан байна. Хүнсний бүтээгдэхүүний шошгод орц, найрлага (ingredients) болон тухайн орц найрлага дахь шимт бодис (nutrition facts)-ын хэмжээг мэдээлдэг байна. Орц, найрлагыг тухайн хүнсний бүтээгдэхүүнд орсон жингийн буурах дарааллаар жагсааж бичнэ. Чихэрлэг орцыг[41] сахароз, глюкоз, фруктоз, сорбитол (sorbitol), маннитол (mannitol), эрдэнэшишийн сироп, фруктоз өндөртэй эрдэнэшишийн сироп зэргээр тэмдэглэдэг байна. Үүний сацуу тухайн бүтээгдэхүүний найрлаган дахь шимт бодисыг мэдээлнэ. Тус журамд хүнсний бүтээгдэхүүний найрлага дахь шимт бодисын хоногт хэрэглэх зөвлөмж (Daily Value)-д тухайн шимт бодисын хоногийн зохих тунг насны ангиллаар гаргасан байна. Харин “чихэр”-т хоногийн зөвлөмж хэмжээ тавьдаггүй байна. АНУ нь ДЭМБ-аас боловсруулсан зөвлөмжийн дагуу хүнсний бүтээгдэхүүн дэх чихрийн агууламжийг бууруулах бодлогыг баримталдаг. Насанд хүрэгчид болон хүүхэд хоол хүнснээс өдөрт авах илчлэгийн 10%-аас ихгүй нэмэлт чихрийг хоол хүнсэндээ хэрэглэхийг зөвлөдөг байна.[42]

“Америкчуудын хоол хүнсний удирдамж 2020-2025” (Dietary Guidelines for Americans 2020-2025), Сургуулийн хүүхдийн Өглөөний цай, Өдрийн хоол хөтөлбөрт тус тус бага болон дунд насны хүүхэд, түүнчлэн нярай хүүхдийн хоол хүнсэн дэх чихрийн агууламжийн зохистой хэмжээг зөвлөсөн байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд хүн амын дунд таргалалт, чихрийн шижин, зүрх судасны өвчин ихэссэн бөгөөд бага насны хүүхдэд мөн ялгаагүй энэ төрлийн өвчлөл, ялангуяа таргалалт эрс нэмэгдсэн байна. Энэ нь хоол хүнсэн дэх чихрийн орц ихэссэнтэй шууд холбоотой төдийгүй хэрэглэгчдэд ойлгомжгүй, ярвигтай байдаг нь эрүүл хүнс сонгох боломжийг хязгаарладаг тул бүтээгдэхүүний шошгыг ойлгоход хялбар болгох, савлагааны нүүрэн талын шошгыг хуульчлах зэрэг шошготой холбоотой бусад асуудлуудыг шийдвэрлэх үүднээс 2021 онд Конгрессын нэр бүхий гишүүд Хүнсний шошгыг шинэчлэх тухай хууль (Food Labeling Modernization Act)-ийн төслийг Конгресст өргөн барьсан байна.

Шударгаар савлах болон шошголох тухай хууль: Тус хуулийг 1967 онд баталсан бөгөөд Холбооны Худалдааны комисс хийгээд Хүнс болон эмийн захиргаанд бүх бараа, бүтээгдэхүүний нийт агууламж, бүтээгдэхүүний нэр, үйлдвэрлэсэн, савласан газар болон борлуулагчийн нэр хаяг зэргийг багтаасан шошгоор шошголох тухай журам батлан, хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон байна. Мөн хуулиар хэрэглэгчдийг хууран мэхлэгдэхээс урьдчилан сэргийлэх үүднээс бүтээгдэхүүний орц, найрлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, ижил төрлийн бараа, бүтээгдэхүүнтэй харьцуулж болохуйц, шаардлага хангасан шошго ашиглах, үнэн зөв савлагаа, дүүргэлт бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар нэмэлт журмыг боловсруулж, хэрэгжүүлэхийг дээрх байгууллагуудад үүрэг болгожээ.

[40] https://www.ecfr.gov/current/title-21#0

[41] https://www.fda.gov/food/food-ingredients-packaging/overview-food-ingredients-additives-colors#types

[42] https://www.fda.gov/food/new-nutrition-facts-label/added-sugars-new-nutrition-facts-label

АНУ-ын Худалдааны яамны харьяа Үндэсний стандарт, технологийн хүрээлэнгийн Жин хэмжүүрийн албанд Холбооны болон мужийн бараа бүтээгдэхүүний шошгын стандартыг жигд болгохыг үүрэг болгожээ. Шошгод дараах мэдээллийг багтаасан байна:

- Хүнсний бүтээгдэхүүнийг тодорхойлсон нэр;
- Хүнсний бүтээгдэхүүний шимт бодисын агууламжийн жагсаалт (тоон үзүүлэлтээр илэрхийлсэн байх);
- Хүнсний бүтээгдэхүүний жин;
- Үйлдвэрлэсэн, савласан этгээдийн болон борлуулагчийн нэр, хаяг байршил;
- Харшил үүсгэж болзошгүй бодисын тэмдэглэл зэрэг орно.

Шим тэжээлийн шошго болон түүний талаар мэдлэг олгох тухай хууль: 1990 онд батлагдсан энэ хуулиар АНУ-ын Эрүүл мэндийн яамны харьяа Хүнс болон эмийн захиргаанд тус улсад үйлдвэрлэгдэж буй дийлэнх боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод хяналт тавих эрхийг олгосон байна. Шим тэжээлийн шошго болон түүний талаар мэдлэг олгох тухай хуулиар, хэрэглэгчдэд эрүүл, аюулгүй хүнсний сонголт хийхэд туслах үүднээс хүнсний бүтээгдэхүүний шошгыг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар болгох, үүний сацуу үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүний чанараа сайжруулахад түлхэц болохыг зорьсон байна.

Хүнс болон эмийн захиргаа нь үйлдвэрлэгчдээс хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага дахь шим тэжээлийн дэлгэрэнгүй мэдээллийг шаардах эрхтэй. Хүнсний шошго дээр 14 шимт бодисыг заавал тэмдэглэхээр заасан бөгөөд тухайн хүнсний бүтээгдэхүүнд орсон жингийн буурах дарааллын дагуу тэмдэглэхээр зохицуулсан байна. Хүнсний бүтээгдэхүүний шошгын шимт бодисын мэдээлэлд “Чихэр”-ийн агууламжийг “Нийт чихрийн хэмжээ” (Total sugar) гэж тэмдэглэхээр заасан.

Харин 2016 онд хэрэглэгчдийн эрүүл мэндийг хамгаалах, хүнсний бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдэд үнэн, бодит мэдээллийг олгох үүднээс бүтээгдэхүүний шошго дээрх “Шимт бодисын мэдээлэл”-ийг шинэчлэн баталсан байна. Шинээр батлагдсан “Шимт бодисын мэдээлэл”-д “Нэмэлт чихэр” (Added Sugar)-ийн мэдээллийг “Нийт чихрийн хэмжээ” мэдээллийн доод талд догол мөрөнд зайлшгүй мэдээлж байхаар заажээ.[43] Шимт бодисын хоногт хэрэглэх зөвлөмжийг мэдээлдэг хэдий ч “чихэр”-ийн хувьд зөвлөдөггүй. Харин хүний биед хэрэгцээт Өдрийн илчлэгийн хэдэн хувийг тухайн бүтээгдэхүүн дэх нэмэлт чихэр бүрдүүлж байгааг “х%” гэж тэмдэглэдэг байна.[44] 2017 онд Хүнс болон эмийн захиргаанаас шинэчлэн баталсан шошгоор бүтээгдэхүүнээ шошголох тодорхой хугацааг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд үүрэг болгосон байна. Үүнд, жилд 10 сая ам.доллар болон түүнээс дээш хэмжээний борлуулалттай бол 2018 оны 07-р сараас 2020 оны 01-р сар хүртэл, харин жилд 10 сая ам.доллараас бага борлуулалттай бол 2019 оны 07-р сараас 2021 оны 01-р сар хүртэл хугацааг тус тус



[43] https://extranet.who.int/nutrition/gina/en/node/25408

[44] https://www.fda.gov/food/new-nutrition-facts-label/added-sugars-new-nutrition-facts-label

олгожээ.

Холбооны журмын 21-р бүлэг Хүнс болон эм, 101 Хүнсний шошго хэсэг нь доорх дэд хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- A дэд хэсэг. Шошгын талаар ерөнхий мэдээлэл;
- B дэд хэсэг. Хүнсний шошгод тавигдах тусгай шаардлага;
- C дэд хэсэг. Шимт бодисыг шошголох тусгай шаардлага, удирдамж;
- D дэд хэсэг. Шимт бодисын агууламжид тавигдах тусгай шаардлага;
- E дэд хэсэг. Эрүүл мэндийн мэдэгдэлтэй холбоотой тусгай шаардлага;
- F дэд хэсэг. Бусад шаардлагууд;
- G дэд хэсэг. Хүнсний шошгод тавигдах шаардлагаас чөлөөлөх зэрэг болно.

Холбооны журмын 21-р бүлэг Хүнс болон эм, 101.9 Хүнсэн дэх шимт бодисыг шошголох хэсгийн (c) (6)-р хэсэгт “Нийт нүүрс ус”, үүн дотор (i) Хүнсний эслэг, (ii) Нийт чихэр, (iii) Нэмэлт чихэр, (iv) Чихрийн спиртийг хэрхэн шошголох талаар зохицуулсан байна.[45]

“Нийт чихэр” гэдэгт моносахар болон дисахар (глюкоз, фруктоз, лактоз болон сахароз) багтдаг байна. Тухайн савласан бүтээгдэхүүнд агуулагдах чихрийн хэмжээг тоогоор илэрхийлэх бөгөөд хэмжих нэгж нь грамм (гр) байна. 1гр-аас бага хэмжээний чихэр агуулсан тохиолдолд Шошгон дээрх шимт бодисын мэдээллийн доод талд “Чихрийн бодитой эх үүсвэр болохгүй” гэж тэмдэглэдэг байна. Савласан бүтээгдэхүүний чихрийн агууламж хэмжээг 1гр-аас бага тохиолдолд түүнийг тоогоор илэрхийлэх бөгөөд харин 0.5гр-аас бага тохиолдолд “0”-ээр тэмдэглэж болно.

“Нэмэлт чихэр” гэдэг нь хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулах явцад нэмсэн чихэр бөгөөд үүнд (бүх чихэр, моносахар, дисахар) чихрийн ханд, зөгийн бал, жимсний уусмал, ногооны шүүснээс гаргаж авсан чихэр зэрэг ордог байна. Тухайн бүтээгдэхүүн байгалийн гаралтай чихэр болон нэмэлт чихрийг зэрэг агуулж байгаа тохиолдолд үйлдвэрлэгч нь нэмэлт чихрийн хэмжээг шошго дээр заавал мэдээлнэ.

(c) (9)-д хүнсний бүтээгдэхүүний найрлага дахь шимт бодисын Хоногт хэрэглэх зөвлөмжийг насны ангиллаар тогтоосон байх бөгөөд, үүнд, нэмэлт чихрийн агууламжийг дараах байдлаар тогтоожээ.

Хүнсний орц найрлага	Хэмжих нэгж	Насанд хүрэгсэд болон ≥4 насны хүүхэд	12 сар хүртэлх нярай хүүхэд	1-3 хүртэлх насны хүүхэд	Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд
Нэмэлт чихэр	Грам (гр)	50*	Нэмэхгүй	25**	50*

- Насанд хүрэгсэд, 4 болон түүнээс дээш насны хүүхдүүд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийн хоол хүнснээс авах өдрийн илчлэгийг 2000 ккал гэж тооцсон байна.
- **1-3 хүртэлх насны хүүхдийн хоол хүнснээс авах өдрийн илчлэгийг 1000 ккал гэж тооцсон байна.
- 12 сар хүртэлх хүүхдийн хоол тэжээлд нэмэлт чихэр хийхийг хориглодог.

101.9-ийн (j) (5)-д:

[45] https://www.ecfr.gov/current/title-21/chapter-I/subchapter-B/part-101/subpart-A/section-101.9

(i) Нярай хүүхдийн сүүнээс бусад, 12 сар хүртэлх нярай болон 1-3 нас хүртэлх хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод шимт бодисыг заавал мэдээлсэн байна. 12 сар хүртэлх нярай болон 1-3 нас хүртэлх хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шимт бодисын мэдээлэлд илчлэг, нийт тос, ханасан тос, транс тос, натри, нийт нүүрс ус, хүнсний эслэг, нийт чихэр, нэмэлт чихэр, уураг болон дараах витамин, эрдэс бодисуудыг заавал багтаасан байна: витамин Д, кальци, төмөр болон кали гэж заажээ.

(ii) Нярай хүүхдийн сүүнээс бусад, 12 сар хүртэлх нярай хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод дараах зүйлсийг мэдээлэхийг хориглоно. Үүнд:

(A) Тос, ханасан тос, транс тос, натри, хүнсний эслэг, нийт чихэр, нэмэлт чихэрт Хоногт хэрэглэх зөвлөмж хэмжээ тавих болон эдгээр шимт бодисуудад нэмэлт тайлбар тавихыг хориглоно.

(iii) Нярай хүүхдийн сүүнээс бусад, 1-3 нас хүртэлх хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгод “Хоногт хэрэглэх зөвлөмж нь шимт бодисын Өдрийн илчлэгийн хэдэн хувийг бүрдүүлж байгааг илэрхийлнэ. Хоол хүнснээс өдөрт авах илчлэгийн зохист хэмжээ 1000 ккал.” гэсэн нэмэлт тайлбарыг хийнэ гэжээ. Тухайлбал[46]:

Зураг 3. АНУ-ын нярай болон бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгын загвар

12 сар хүртэлх нярай хүүхдэд зориулсан

Nutrition Facts

4 servings per container

Serving size **1 pack (70g)**

Amount per serving

Calories **25**

	% Daily Value
Total Fat 0g	**0%**
Saturated Fat 0g	
Trans Fat 0g	
Cholesterol 0mg	
Sodium 75mg	
Total Carbohydrate 5g	**5%**
Dietary Fiber 1g	
Total Sugars 3g	
Includes 0g Added Sugars	
Protein 0g	**0%**
Vitamin D 0mcg	0%
Calcium 10mg	4%
Iron 1mg	10%
Potassium 230mg	35%

1-3 нас хүртэлх хүүхдэд зориулсан

Nutrition Facts

1 serving per container

Serving size **1 container (85g)**

Amount per serving

Calories **70**

	% Daily Value*
Total Fat 1.5g	4%
Saturated Fat 0.5g	5%
Trans Fat 0g	
Cholesterol 10mg	3%
Sodium 240mg	16%
Total Carbohydrate 11g	7%
Dietary Fiber 1g	7%
Total Sugars 1g	
Includes 1g Added Sugars	4%
Protein 3g	23%
Vitamin D 0mcg	0%
Calcium 35mg	6%
Iron 0.6mg	8%
Potassium 30mg	0%

* The % Daily Value (DV) tells you how much a nutrient in a serving of food contributes to a daily diet. 1,000 calories a day is used for general nutrition advice.

Журмын 101.60 (c) (1)-д заасан “чихэр агуулаагүй”, “чихрийн агууламжгүй” зэрэг мэдэгдлүүдийг орц, найрлагадаа илтэд чихрийн агууламж бүхий хоол хүнсэнд, ялангуяа нярай болон 2-оос доош насны хүүхдэд тусгайлан зориулсан хоол хүнсний шошго дээр тавихыг хориглоно гэжээ.[47]

[46] https://www.ecfr.gov/current/title-21/chapter-I/subchapter-B/part-101

[47] https://www.ecfr.gov/current/title-21/chapter-I/subchapter-B/part-101/subpart-D/section-101.60#p-101.60(c)(1)

Тус журмын 107-р хэсгээр[48] нярай хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний орц, найрлага, түүнд тавигдах шаардлага, шимт бодисын шошго, шошгод тавигдах шаардлага зэргийг зохицуулсан байна. Холбооны Хүнс, Эм, Гоо сайхны тухай хуулийн 201(z) хэсэгт зааснаар хүүхдийн сүүн бүтээгдэхүүний шошгод шим тэжээлийн мэдээллийг өгөгдсөн дарааллын дагуу, заасан нэгжээр, хүснэгт хэлбэрээр илэрхийлэх бөгөөд 100 ккал тутамд зөвшөөрөгдөх доод болон дээд хэмжээг заасан байна. Хүүхдийн сүүний найрлагад дараах шим тэжээлүүдийг заавал багтаасан байх шаардлагатай. Үүнд:

- Уураг
- Тос
- Линолийн хүчил,
- **Витаминууд** A, Д, E, K, B1, B2, B6, B12, ниацин, фолийн хүчил, пантотений хүчил, биотин, С витамин, колин, инозитол,
- **Эрдэс бодисууд** кальци, фосфор, магни, төмөр, цинк, манган, зэс, иод, селен, натри, кали, хлорид тус тус орно.

Савласан бүтээгдэхүүний Нүүрэн талын шошго (Facts Up Front): Хэрэглэгчдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй хүнс сонгоход нь туслах үүднээс хүнсний бүтээгдэхүүний савлагааны нүүрэн хэсэгт тухайн бүтээгдэхүүн дэх хүний биед нэн шаардлагатай шим тэжээлийн хэмжээг ойлгоход хялбар байдлаар мэдээлдэг байна. АНУ-д Хүнс үйлдвэрлэгчдийн холбооноос анх санаачлан, хэрэгжүүлсэн бүтээгдэхүүний нүүрэн талын шошгыг одоогоор хуульчлаагүй бөгөөд хүнс үйлдвэрлэгчид сайн дурын үүднээс мэдээлдэг байна.

Хэрэглэгчдэд ойлгоход хялбар, эрүүл хүнс сонгоход нүүрэн талын шошго чухал ач холбогдолтой болох нь бусад орнуудын туршлагаар батлагдсан тул бүтээгдэхүүний нүүрэн талын шошго болон хүнсний шошготой холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх үүднээс Хүнсний шошгыг шинэчлэх тухай хуулийн төслийг 2021 онд Конгресст өргөн барьсан байна.

“Америкчуудын хоол хүнсний удирдамж”-д хязгаарлахыг зөвлөдөг шимт бодисууд-ханасан тос, натри, нийт чихэр болон илчлэгийн хэмжээг Нүүрэн талын шошгод мэдээлдэг. Үйлдвэрлэгчид үүн дээр нэмээд хүний биед шаардлагатай 2 хүртэлх шимт бодис (кали, эслэг, уураг, витамин А, С, Д, кальци болон төмөр)-ыг нэмж мэдээлэх боломжтой бөгөөд тухайн бодис нь уг бүтээгдэхүүний найрлагад Хоногт хэрэглэх зөвлөмжийн 10%-аас дээш хувиар агуулагдсан байх шаардлагатай байна.



Бүтээгдэхүүний савласан хэмжээнээс шалтгаалан нүүрэн талын шошгод эдгээр мэдээллийг бүгдийг багтаах боломжгүй тохиолдолд тухайн бүтээгдэхүүний илчлэгийн хэмжээг мэдээлдэг байна.

[48] https://www.ecfr.gov/current/title-21/chapter-I/subchapter-B/part-107

3.4.Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

Бүгд Найрамдах Солонгос Улс нь 2020 оны байдлаар дэлхийд 10 дугаарт орох том эдийн засагтай улс бөгөөд хүнсний хэрэгцээнийхээ 45 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангадаг[49]. БНСУ-ын хүнсний салбарыг зохицуулах голлох үүрэгтэй яам нь Хүнс, эмийн аюулгүй байдлын яам (MFDS) юм. Тус яамны үндсэн үүрэг нь хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, улмаар хүнсний аюулгүй байдалтай холбоотой бүхий л шаардлага тэр дундаа хөдөө аж ахуй, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн, импортын хүнсний бараа зэрэгт хяналт тавьж зохицуулах үүрэгтэй.

Тус улсын хувьд хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүн, түүнд орсон чихрийн хэрэглээний асуудал бусад улс орнуудын адил тулгамдсан асуудлын нэг болж байгаа бөгөөд хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгололтыг тусгай стандартаар нарийвчлан зохицуулсан байна. Нялх болон бага насны хүүхдийг асрах тухай хуульд зааснаар 0-3 нас хүүхдийг нярай хүүхэд гэж, Бага насны хүүхдийн боловсролын тухай хуульд зааснаар бага насны хүүхэд гэж 3-6 хүртэлх насны хүүхдийг ойлгоно гэж заажээ.

Хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний орц найрлага, шошготой холбоотой харилцааг дараах нарийвчилсан хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

- Хүүхдийн хоол тэжээлийн аюулгүй байдлын хяналтын тухай тусгай хууль, 2008 (Special Act on Safety Control of Children’s Dietary Life)
- Хүүхдийн дуртай хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага болон шошгын стандартын тухай журам, 2011 (Regulations on the labeling standards and methods of nutritional ingredients for children's favorite foods)[50]
- Хүнсний бүтээгдэхүүний шошгын стандарт, 2003 (Foods Labeling Standards)
- Хүүхдийн бүтээгдэхүүний аюулгүй байдлын нийтлэг стандарт, 2015 (Common safety Standard of Children’s Products) зэрэг болно.

Хүүхдийн хоол тэжээлийн аюулгүй байдлын хяналтын тухай тусгай хууль: Энэхүү хуулийн зорилго нь хүүхдийг аюулгүй, шим тэжээлтэй хоол хүнсээр хангахад шаардлагатай зүйлсийг тогтоож өгөх замаар хүүхдийн эрүүл мэндийг дэмжих юм. Хуульд зааснаар “хүүхдийн дуртай хоол” гэж Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон хүнсний бүтээгдэхүүнүүд дунд хүүхдийн илүүд үздэг буюу байнга хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүнийг хэлнэ гэж тодорхойлжээ.

Хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг бүрдүүлэн хамгаалах үүргийг орон нутгийн засаг дарга (Си/Гүн/Гу-ийн дарга) хариуцах бөгөөд сургуулиас 200 метр доторх талбайг хүүхдийн хүнсний аюулгүй байдлыг хамгаалах бүс гэж тодорхойлж, илчлэг ихтэй, шим тэжээл багатай хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалахыг хязгаарлах буюу хориглосон. Энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсгийн шошго, шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсгийн өнгөт шошгын талаар заасан бөгөөд стандартыг Солонгосын Хүнс, эмийн удирдлагын комиссар батлахаар заасан. Хүнсний бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийг шошголохтой холбоотой үүргээ биелүүлээгүй бол 10 хүртэл сая вонын торгууль ногдуулахаар заасан.

Хүүхдийн дуртай хүнсний бүтээгдэхүүний орц, найрлага болон шошгын стандартын тухай журам: Энэхүү журмаар Хүүхдийн хоол тэжээлийн аюулгүй байдлын тухай тусгай хууль болон мөн хуулийн хэрэгжилтийг хангах тухай тогтоолын дагуу шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн шошгололт, шошгололтын аргачлалыг тогтоосон.

[49] Exporter Guide, Sangyong OhOctober 14, 2021

[50] https://www.law.go.kr/행정규칙/어린이기호식품등의영양성분표시기준및방법에관한규정/(2011-16,20110329)

Бизнес эрхлэгчид шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бодитой хэмжсэн өгөгдөл, эсхүл шинжлэх ухааны үндэслэлтэй тооцоолсон өгөгдлийг шошголох ёстой.

Хүүхдийн дуртай хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн шошгын стандарт, аргачлал (Журмын 3 дугаар хавсралт):

1. **Шим тэжээлийн найрлагын тэмдэглэгээ/шошго**

Дараах хүнсний бүтээгдэхүүнийг хоол бэлтгэх, худалдан борлуулж буй бизнес эрхлэгч нь журамд заасны дагуу шим тэжээлийн найрлагын тэмдэглэгээг бизнес эрхлэгч хийх ёстой.

- Талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн
- Зайрмаг
- Гамбургер, пицца
- Түүнчлэн шим тэжээлийн найрлагыг бичих шаардлагатай хоол бэлтгэх, худалдан борлуулах хүнсний бүтээгдэхүүн

2. **Шим тэжээлийн талаарх мэдээлэл**

- Илчлэг
- Чихэр
- Уураг
- Ханасан өөх тос
- Натри
- Түүнчлэн онцлох тэмдэглэгээ хийх шаардлагатай бол түүний шим тэжээлийн мэдээлэл

3. **Тэмдэглэгээний стандарт ба аргачлал**

Шим тэжээлийн найрлагыг шошгын стандартын дагуу дараах байдлаар тэмдэглэнэ.

- Шим тэжээлийн найрлагыг түүний нэр болон хувийг тэмдэглэсэн байх ёстой бөгөөд нэг порцын стандарт хэмжээнд агуулагдах хэмжээг зааж өгнө. Энэ тохиолдолд шим тэжээлийн стандарт хувийг хамтад нь тэмдэглэнэ.
- Нэг порц дахь шим тэжээлийн найрлагыг шошголохдоо нэгжийг аяга, ширхэг болон хэсэг зэргээр тэмдэглэж түүнд агуулагдах жин (гр) болон эзэлхүүн (мг)-ийг хаалтад тэмдэглэнэ. 2-оос дээш порцтой бүтээгдэхүүний хувьд нийт порцын хэмжээг зааж өгнө. (1 порц пицца 8 зүсэм: нэг зүсэм нь 150 гр орчим (нэг зүсмийн хэмжээ 100-299 гр)) гэж ойролцоогоор бичнэ)
- Хоёр ба түүнээс дээш төрлийн хүнсний бүтээгдэхүүнээс бүрдсэн бол нийт илчлэгийг заана. Гэхдээ хэд хэдэн төрлийн хүнсний бүтээгдэхүүний хувьд нийт калорийн хамгийн бага ба хамгийн их утгыг зааж өгнө.

Шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг шошгод дараах байдлаар тэмдэглэнэ.

1. Шошгын мэдээллийг хэрэглэгчид хялбар танихын тулд дэвсгэрийн өнгөнөөс ялгаатай өнгөөр харуулах ёстой бөгөөд шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн нарийвчилсан мэдээллийг зааж өгнө.
2. Бизнес эрхлэгч нь дэлгүүрт хоол хийх, худалдах тохиолдолд хоолны нэр, үнийн хамт, илчлэгийн хэмжээг харуулсан байх ёстой.
3. Бизнес эрхлэгч нь цахимаар болон утсаар захиалсан хоолыг хүргэх үед шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан зурагт хуудас, наалт зэргийг хамтад нь өгөх ёстой.
4. Цахимаар худалдан борлуулж байгаа хүнсний бүтээгдэхүүний мэдээлэл өгөхдөө шим тэжээлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тухайн хүнсний нэр, үнийн эргэн тойронд байрлуулна.

Хүүхдийн дуртай хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах шим тэжээлийн нийт хэмжээг өнгө, хэлбэр дүрсээр харуулах стандарт, арга (журмын 4 дүгээр хавсралт)

1.Шошгонд хамаарах хүнсний бүтээгдэхүүн

Зууш[51]ны хувьд:

- Жигнэмэг (солонгос жигнэмэгээс бусад), чихэр, амттан доторх жигнэмэг
- Талх
- Шоколад
- Сүүн бүтээгдэхүүнээс боловсруулсан тос (82.5% ба түүнээс дээш түүхий тос агуулсан сүүн бүтээгдэхүүнээс бусад), исгэсэн сүү, зайрмаг
- Загасны махан бүтээгдэхүүн дотроос загасны хиам
- Ундаанаас жимс, ногооны шүүс, хийжүүлсэн ундаа, сүүн хүчлийн бактер, холимог ундаа

Хоолны хувьд:

- Гоймонгоос шарсан гоймон, хэрчсэн гурил
- Түргэн хоолноос кимбаб, гамбургер, сэндвич

2.Шошгон дээр чихэр, өөх тос, ханасан өөх тос, натрийн мэдээллийг заавал зааж өгнө.

3.Шим тэжээлийн хэмжээгээр эрэмбэлэх өнгөний стандарт

- Шим тэжээлийн нийт хэмжээгээр бүрэлдэхүүн тус бүрийн өнгөний стандартыг дараах байдлаар гаргах бөгөөд энэ стандарт нь нэг порцод агуулагдах хэмжээнд үндэслэсэн болно.

Төрөл		**Өнгө**	**Чихэр**	**Өөх тос**	**Ханасан өөх тос**	**Натри**
Зууш	Бага	Ногоон	3 гр доош	3 гр доош	1.5 гр доош	120 мл доош
	Хэвийн	Цагаан	3 гр дээш, 17 гр доош	3 гр дээш, 9 гр доош	1.5 гр дээш, 4 гр доош	120 мл дээш, 300 мл доош
	Их	Улаан	17 гр дээш	9 гр дээш	4 гр дээш	300 мл дээш
Хоол	Бага	Ногоон	3 гр доош	3 гр доош	1.5 гр доош	120 мл доош
	Хэвийн	Цагаан	3 гр дээш, 17 гр доош	3 гр дээш, 12 гр доош	1.5 гр дээш, 4 гр доош	120 мл дээш, 600 мл доош
	Их	Улаан	17 гр дээш	12 гр дээш	4 гр дээш	600 мл дээш

- Өнгөний стандарт:

Өнгө	**CMYK**				**Өнгөний тохируулга (Pantone)**
	Цэнхэр (Cyan)	**Ягаан (Magenta)**	**Шар**	**Хар**	
Ногоон	50	0	100	0	390C
Цагаан	0	25	100	0	141C
Улаан	0	100	60	0	230C

4.Шим тэжээлийн бүрэлдэхүүний хэмжээг илэрхийлэхдээ дараах загваруудын аль нэгээр илэрхийлнэ.

[51] Хүүхдийн хоол тэжээлийн аюулгүй байдлын хяналтын тухай тусгай хуульд тодорхойлсноор зууш гэж өдрийн цагаар ихэвчлэн хэрэглэдэг хоолноос бусад хүнсний хэрэглээг хэлнэ.

Зураг 4.Шим тэжээлийн бүрэлдэхүүний хэмжээг илэрхийлэх загвар



Хүнсний бүтээгдэхүүний шошгын стандарт: Хүнс, эмийн аюулгүй байдлын яамнаас 2014 онд баталсан энэхүү стандартаар шошго, сав, баглаа боодолд шим тэжээлийн талаарх дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд, калори, нүүрс ус: элсэн чихэр, ууураг, өөх тос:ханасан өөх тос, транс тос, холестрин, натрийн жин, эзлэхүүнийг зааж өгөх ёстой. Үүнээс гадна тухайн хоол тэжээлд шууд ороогүй, түүхий эдэд агуулагдах орц, найрлагын талаар зааж өгөх бол онцлох шошгонд (emphasis labeling) оруулахаар зохицуулжээ. борлуулалт болон олон нийтийн сурталчилгаа зэргийг хязгаарладаг байна.

Шошгын стандарт (Labelling standards): Ерөнхий шошгын стандартаас гадна хүнс, малын гаралтай бүтээгдэхүүний нэмэлт стандартууд багтдаг байна.

БНСУ нь хүнсний бүтээгдэхүүний шошгонд дараах 5 гол шаардлага байдаг. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт;
- Малын гаралтай бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт;

- Боловсруулаагүй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бараа тэмдэгтийн стандарт;
- Согтууруулах ундааны бараа тэмдэгтийн стандарт;
- Улсын гаралтай бүтээгдэхүүний стандарт.

Импортын хүнсний бүтээгдэхүүнд дагаж мөрдөх ёстой хууль тогтоомжийн гол хэсэг юм. Уг стандартын дагуу импортын бүх хүнсний бүтээгдэхүүнд Солонгос хэл дээр бичигдсэн гаргацтай шошго байх ёстой бөгөөд эдгээр шошго нь уг бүтээгдэхүүний анхны шошгыг халхлах ёсгүй, мөн амархан салж хуулрахгүй байх ёстой. Шошго нь дараах зүйлийг агуулсан байна.

- Бүтээгдэхүүний нэр;
- Бүтээгдэхүүний төрөл;
- Импортлогчийн нэр, хаяг;
- Үйлдвэрлэсэн огноо (зарим төрлийн бүтээгдэхүүний хувьд);
- Найрлагын нэр ба агуулга;
- Бүтээгдэхүүний орцод аливаа бодис 5%-аас дээш хувийг эзэлдэг бол нийлмэл орц бэлтгэхэд ашигласан орцын нэрс оруулах;
- Нэмэлтүүд (Хүнсний нэмэлтийн дүрэмд заасан бүтэн буюу товчилсон нэр);
- Харшил үүсгэгч бодис (хамгийн бага түвшинд байсан ч оруулна);
- Шим тэжээл.

Хүнсний бүтээгдэхүүний шошго нь импортын мэдүүлгээс эхлээд худалдаа эрхлэгчид хүргэгдэх хүртэл хяналтад байдаг.

Хүүхдийн бүтээгдэхүүний аюулгүй байдлын нийтлэг стандарт:[52] Энэхүү стандартаар 13-аас доош насны хүүхэд хэрэглэдэг бараа бүтээгдэхүүн, түүний эд анги, дагалдах хэрэгсэлд нийтлэг хэрэглэнэ. Энэхүү стандартад аюултай бодисын аюулгүй байдлын шаардлага, бие махбодын аюулгүй байдлын шаардлага, аюулгүй байдлын шаардлагын туршилтын арга, хяналт шалгалтын арга, аюулгүй байдлын нийтлэг стандартын шошгын талаар нарийвчлан зохицуулсан. Тус стандартад бараа, бүтээгдэхүүний шошгын талаар дараах байдлаар зохицуулжээ. Аюулгүй байдлын нийтлэг стандартын шошго бүхий зүйлсийг харахад хялбар байх үүднээс холбогдох хүүхдийн бүтээгдэхүүний гадаргуу, эсхүл савалгааны нэгж дээр хавсаргах, хэвлэх, сийлбэрлэх, шошголох зэргээр Солонгос хэлээр тэмдэглэсэн байх бөгөөд амархан арилахааргүй байх ёстой. Шошго нь дараах мэдээллийг агуулсан байна. Тухайлбал:

- Үйлдвэрлэгч, эсхүл импортлогчийн нэр;
- Хаяг, утасны дугаар;
- Үйлдвэрлэсэн он, сар;
- Үйлдвэрлэсэн улс;
- Ашиглалтын хугацаа;
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ эсхүл хэрэглэгчийн гарын авлага;
- “КС тэмдэг нь энэ бүтээгдэхүүн нь аюулгүй байдлын нийтлэг стандартад нийцэж байна” гэсэн хэллэгийг бүтээгдэхүүн дээр 12 ба түүнээс дээш оноотой тод харуулсан байх ёстой.

Хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

[52] https://www.law.go.kr/LSW/admRulInfoP.do?admRulSeq=2100000020451

Хүнсний ариун цэврийн тухай хууль[53] (The Food Sanitation Act): Тус хуулийн зохицуулалтууд нь хүнсний аюулгүй байдлыг хангах суурь хууль юм. Мөн үүн дээр Баяжуулсан хүнсний тухай хууль нэмэгддэг ба энэ нь баяжуулсан хоол хүнс, тэр дундаа эрүүл хоол хүнс, нэмэлт тэжээлд хяналт тавих эрх зүйн үндсийг бүрдүүлдэг.

Импортын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тухай тусгай хууль (Special Act on Imported Food Safety Management): Импортын хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой бодлого, эрх зүйн орчинг уг хуулиар зохицуулдаг байна. Тус хуулийг 2016 онд шинэчлэн найруулсан ба бусад хууль тогтоомжид байсан импортын хүнстэй холбоотой бүх зохицуулалтыг нэгтгэсэн.

Хүнсний код (Food Code): Уг кодоор хүнсний үйлдвэрлэл, боловсруулалт, хэрэглэх, хадгалах стандартуудыг тусгасан байна. Түүнчлэн хөдөө аж ахуйн химийн бодис, мал эмнэлгийн эмийн үлдэгдлийн дээд хэмжээ, цацраг идэвхт туяаны стандарт, бохирдуулагч бодис зэргийг зааж өгсөн байна.

Хүнсний нэмэлт орцны код (The Food Additive Code[54]): Тус кодоор хүнсний бүтээгдэхүүнд орж буй нэмэлт орц, стандарт үзүүлэлтүүдийг тодорхойлсон байдаг.

Хүүхдийн хүнсний зохистой хэрэглээний тухай хууль (The Special Act on Children's Dietary Life Safety Management): Хүүхдийн хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүнд голлон хяналт тавьдаг ба зарим илчлэг ихтэй, кофейн өндөртэй хүнсний бүтээгдэхүүний борлуулалт болон олон нийтийн сурталчилгаа зэргийг хязгаарласан байна.

Түүнчлэн Таргалалтаас сэргийлэх бодлого (Policy-Obesity Prevention Measures), сургуулийн эрүүл мэндийг дэмжих бодлого (Policy-Health Promotion at School), Эмэгтэйчүүд, нялхас, хүүхдэд зориулсан нэмэлт бүтээгдэхүүний бодлого (Policy-NutriPlus+for women. Infants&children) зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлж байна.

3.5.Канад Улс

Канад Улсын Эрүүл мэндийн яамнаас 2015 онд хийсэн нийт чихрийн хэрэглээний талаарх судалгаагаар 1-8 насны хүүхдийн чихрийн хоногийн дундаж хэрэглээ нь 101 грамм (24 цайны халбага), 9-18 насны хүүхдэд 115 грамм (27 цайны халбага), насанд хүрэгчид 85 грамм (20 цайны халбага) гэсэн үр дүн гарсан байна. Энэхүү чихрийн өндөр хэрэглээний үр дүнд хүүхдийн шүд цоорох, илүүдэл жингийн асуудал цаашлаад чихрийн шижин өвчлөлийн эрсдэлийг бууруулах, мөн ДЭМБ-ийн чихрийн хэрэглээг 10%-аас бага хэмжээнд хүртэл бууруурах зөвлөмжийн дагуу Канадын Эрүүл мэндийн яамнаас зорилтот ажлуудыг хийж байна.

Энэ хүрээнд 2022 онд Эрүүл мэндийн байгууллагаас Хүнс, эмийн тухай хуульд ханасан өөх тос, чихэр, натрийн орцтой бүтээгдэхүүний савалгааны шошгонд тавигдах шинэ шаардлага, ханасан өөх тос, чихэр, натри орсон эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний агууламжид хязгаарлалт хийх, чихрийн орц ихтэй амтлагчийн шошгыг өөрчлөх талаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Мөн Канад Улсын чихрийн институтээс хүүхэд, өсвөр насныхны чихрийн хэрэглээг тогтмол судалж судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн дүн шинжилгээнд суурилсан үр дүнгийн судалгааг тогтмол хийн өсвөр насныхан, эцэг эх, асран хамгаалагч болон насанд хүрэгчдэд эрүүл хооллолтын гарын авлага болон аливаа хүнсний бүтээгдэхүүний шошго дээрх орц, найрлагын мэдээллийг зөв уншиж, сонголтоо хийхийг цахим сүлжээнд зар сурталчилгаа, танилцуулгыг тогтмол явуулж байна.

---

[53] https://www.mfds.go.kr/eng/brd/m_15/list.do

[54] https://www.foodsafetykorea.go.kr

Канад Улсад хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн шошгын стандартыг Канадын эрүүл мэндийн газар болон Хүнсний хяналтын агентлаг хариуцан ажилладаг. Хүнсний бүтээгдэхүүний шошго нь дараах үндсэн гурван үүрэгтэй. Тухайлбал,

• Бүтээгдэхүүний үндсэн мэдээллийг мэдээлэх- (нийтлэг нэр, орцын жагсаалт, цэвэр тоо хэмжээ, хугацаа, гарал үүсэл, диллер, импортлогчийн нэр, хаяг)

• Эрүүл мэнд, аюулгүй байдал, хоол тэжээлийн мэдээллийг мэдээлэх- (аюулгүй хадгалалт, хэрэглэх зааварчилгаа, нэг порцод агуулагдах өөх тос, уураг, нүүрс ус, витамин, эрдэс бодисын хэмжээ болон тусгай нэмэлт бүтээгдэхүүний талаарх мэдээлэл)

• Хүнсний маркетинг, сурталчилгаа болох - (сурталчилгааны мэдээлэл, шошгон дээрх "өөх тос багатай", "холестеролгүй", "эслэг ихтэй", “байгалийн", "органик", "хадгалагч бодис нэмээгүй" "Канадын бүтээгдэхүүн" гэх мэт зар сурталчилгааны хэрэгсэл болох).

Канадын Хүнсний хяналтын агентлаг (Canadian Food Inspection Agency)[55]**:**

Хүнс, эмийн тухай хуулийн дагуу Канад Улсад худалдаалагдаж буй хүнсний бүтээгдэхүүн, эрүүл мэнд, гоо сайхны бүтээгдэхүүний аюулгүй байдал, шим тэжээлийн чанарт хамаарах эрүүл ахуйн бодлого, стандарт, хүнсний шошгын стандартыг боловсруулах, хяналт шалгалт хийх үйл ажиллагааг Эрүүл Мэндийн Газар болон Канадын Хүнсний Хяналтын Агентлаг хариуцан ажилладаг.

Канадын чихрийн институт (Canadian Sugar Institute)[56]: Тус институт нь эрүүл мэндийн мэргэжилтэн, сургагч багш, хэвлэл мэдээллийн салбарын ажилчдаас бүрдсэн чихэр, нүүрс усны талаар шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа шинжилгээтэй үнэн бодит мэдээллээр хоол тэжээлийн шимт бодис, орц найрлага, хэрэглэх зааврын талаарх мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд Дэлхийн чихрийн судалгааны байгууллага (World Sugar Research Organisation)-ын гишүүн юм. Энэхүү институт нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Элсэн чихэр, нүүрс усны талаар эрүүл мэндийн үзүүлэлтийн хувьд шинжлэх ухааны нотолгоотой дүн шинжилгээ, судалгаа хийх;
- Шинжлэх ухааны нотолгоо баримттай судалгаа, мэдээ мэдээллийг тогтмол хийн, шинэчлэн олон нийтэд танилцуулах, сурталчлах, зөв хэрэглээнд сургах;
- Судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээ мэдээлэл, эрдэм шинжилгээний мэргэжлийн баг болон эрүүл мэндийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах;
- Олон нийтэд танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг хүргэх, эрүүл хооллолтын талаар танин мэдүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Хууль, эрх зүйн орчин

Канад Улсад бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгын стандартын тухай тусгайлсан хууль байхгүй бөгөөд хүнсний бүтээгдэхүүн, шошгонд тавигдах стандарт, хяналт зэрэг харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Тухайлбал,

- Хүнс, эмийн тухай хууль;
- Хүнс, эмийн тухай журам;
- Хүнсний аюулгүй байдлын тухай хууль;
- Сав баглаа боодол, шошгололтын тухай хууль.

[55] Canadian Food Inspection Agency https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-16.5/page-1.html#h-68016

[56] Canadian Sugar Institute https://sugar.ca/about-us/strategic-priorities

Хүнс, эмийн тухай хууль (Food and Drugs Act)[57]- нь нийт иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, хоол хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, шаардлага, хэрэглээнд хяналт тавих зорилготой. Тус хуулийн нэгдүгээр бүлгээр Эм, эмийн бүтээгдэхүүн хоёрдугаар бүлгээр Хүнс тэжээл гэж тусгайлан зохицуулсан байна. Хуульд бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошгололт, чихрийн агууламжийн талаар дараах байдлаар зохицуулсан байна. Тухайлбал,

- 6-12 сар хүртэлх хүүхдийн хоол тэжээлийн шошго гэсэн дэд бүлэгт[58]: 6-12 сар хүртэлх хүүхдийн савласан бүтээгдэхүүнд өөх тос, эслэг, элсэн чихэр, холестерол, натри, ханасан тосны хүчил, транс тосны хүчлийг агуулж болохгүй.
- 2 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн шошгонд өөх тос, натри, нүүрс ус, эслэг, чихэр, ууураг, А, С аминдэм, кальци, төмрийн орц найрлагыг тодорхой тусгана.
- Нэмэлт хоол гэдэг нь нярай болон 1-4 насны хүүхэд, жирэмсэн эхчүүд хэрэглэх чихрийн орц найрлагагүй, зөвшөөрөгдсөн хүнсний бүтээгдэхүүний ангилалд багтсан тусгай савлагаа, шошготой хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг хэлнэ.
- Чихэрлэг бодис: хэсэгт чихрийн химийн орц найрлага, чихрийн төрөл, нэршил зэргийг нарийвчлан тусгаж өгсөн байна.
- Нярайн хоол: Эхийн сүү орлуулагчаас бусад хүнсний хяналтын хуудсанд зааснаас илүү натрийн агууламжтай хоол хүнсийг худалдаж борлуулахыг хориглоно.

Шим тэжээлийн шошго (Nutrition Labeling)[59]

Шим тэжээлийн шошгыг цагаан дэвсгэр дээр, эсхүл 5%-ийн өнгө холилдсон жигд дэвсгэр дээр тод хар өнгөөр англи, франц хэлээр тэмдэглэнэ. Шошгон дээр хэрэглэх хэмжээ, илчлэг чанар, өөх тос, нүүрс ус, уургийн хэмжээ болон нэмэлт бүтээгдэхүүний тайлбар, нэмсэн чихрийн хэмжээ, эрдэс, витамины орцыг заавал оруулсан байна.

Шошго дээрх чихрийн хэмжээний талаарх тэмдэглэгээ[60]

Төрөл (Item)	Тодорхойлолт (Description)	Нэгж (Unit)	Хэмжих арга (Manner of expression)
Чихрийн хэмжээ	Чихэр (Sugar)	-заасан хэмжээ тутамд граммаар хэмжих -өдөрт авах илчлэгийн хэмжээ	(а) бага хэмжээ нь 0,1-0,5 гр (б) их хэмжээ нь 0,5-1 гр Илчлэгийн хувьд 0% эсхүл 1% хүртэл

Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (Safe Food for Canadians Act)[61]- Тус хуулиар хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт шалгалт хийх зарчим, шошго, зар сурталчилгаа, импорт, экспорт, улс доторх хүнсний худалдаа, тусгай зөвшөөрөл болон хяналтын байгууллагын чиг үүргийг тодорхойлсон.

Сав, баглаа боодол, шошгололтын тухай хууль (Consumer Packaging and Labeling Act)[62]-аар Хүнс, эмийн тухай хуульд заасан хоол хүнс, эм, эмийн бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгын стандартыг нарийвчлан зааж өгсөн.

---

[57] Food and Drugs Act https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/f-27/page-1.html

[58] Foods for Infants Six Months of Age or Older but Less Than One Year of Age https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/c.r.c.%2C_c._870/page-12.html#h-568940

[59] Nutrition Labeling https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/C.R.C.%2C_c._870/page-54.html#h-1372046

[60] Core. Information https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/C.R.C.%2C_c._870/page-54.html#h-1372046

[61] Safe Food for Canadians Act https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/S-1.1/FullText.html

[62] Consumer Packaging and Labeling Act https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/C-38/FullText.html

Шошгын шаардлагын хяналтын хуудас нь Хүнс, эмийн тухай хууль болон Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд заасан шаардлагуудыг хянах хяналтын хуудас (Thresholds Requiring a Nutrition Symbol)[63] бөгөөд Хүнсний хяналтын агентлагаас зөвшөөрөгдсөн шим тэжээлийн агууламжийг баталгаажуулах, мөн хяналтын хуудасны загварыг бэлтгэн гаргаж тогтмол шинэчилж, тавигдах шаардлагын дагуу хүүхэд болон насанд хүрэгчдийн хүнснээс авч байгаа илчлэг, шим тэжээлийн хувь хэмжээг тодорхойлж хянадаг.

Хүнсний бүтээгдэхүүний шошгон дээрх чихрийн тэмдэглэгээ:[64]

2022 онд Канадын эрүүл мэндийн байгууллагаас Хүнс, эмийн тухай хуульд:

- Ханасан өөх тос, чихэр, натрийн орцтой бүтээгдэхүүний савлагааны шошгонд тавигдах шинэ шаардлага;
- Ханасан өөх тос, чихэр, натри орсон эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний агууламжид хязгаарлалт хийх;
- Чихрийн орц ихтэй амтлагчийн шошгыг өөрчлөх гэсэн нэмэлт өөрчлөлт оруулсан.

Зураг 5.Шошгын загвар



Эх сурвалж: https://sugar.ca/sugars-consumption-guidelines/nutrition-labelling-and-claims

Зураг 6.Орц найрлага загвар



[63] Thresholds Requiring a Nutrition Symbol https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/C.R.C.,_c._870/page-9.html#h-1371245

[64] Sugars in the nutrition facts table https://www.canada.ca/en/health-canada/services/food-labelling-changes/sugars.html

Тайлбар: Хэрэглэгчдэд хүнсний бүтээгдэхүүнд орсон чихрийн бүх орц, найрлагыг ойлгомжтой болгохын тулд Чихэр гэсэн үндсэн нэрийн ард хаалтанд нэмсэн чихрийг жагсаах бөгөөд хамгийн их орцтойгоос нь бага руу жагсаан бичнэ.

3.6.Монгол Улс

Монгол Улсад 2017 онд хийгдсэн “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн тулгамдсан асуудал” үндэсний V судалгаагаар нийт хүн амын дунд эрүүл бус хоол, хүнсний хэрэглээ түгээмэл болж илүүдэл жин, таргалалт 2010 оноос эрс нэмэгдсэн дүн гарчээ. Үүнийг насны ангиллаар авч үзвэл, хоол тэжээлийн IV судалгаагаар 15-49 насны эрэгтэйчүүдийн 27.6% нь илүүдэл жинтэй, 5.9% нь таргалалттай байсан бол V судалгааны дүнгээр тухайн насны эрэгтэйчүүдийн 48.8% нь, эмэгтэйчүүдийн 46.2% нь илүүдэл жинтэй, таргалалттай байна. Мөн сургуулийн дөрвөн сурагчийн нэг, тав хүртэлх насны найман хүүхдийн нэг нь илүүдэл жинтэй байгаа нь онцгойлон анхаарах ёстой асуудал болж буйг уг судалгаа харуулсан. Судалгаагаар 2016-2017 оны байдлаар нийт хүн амын дийлэнх буюу 74.6% нь өдөрт 2 ба түүнээс дээш удаа чихэр агуулсан хоол хүнс хэрэглэж байгаа бөгөөд 1 хүнд өдөрт 15.8 кг чихэр ногдож байна гэсэн дүн гарсан.

Өнөө цагт хүмүүс энгийн, зөв амьдралын хэв маягийн талаар ойлголттой болж эрүүл хооллолтод анхаарах болсон ч нийтийг хамарч чадахгүй байна. Тухайлбал, сургуулийн сурагчдын 99% нь аль нэг төрлийн эрүүл бус хүнс, 97.8% нь чихэрлэг хүнс, 80.9% нь чихэртэй ундааг долоо хоногт нэгээс дээш удаа хэрэглэдэг нь эрүүл бус хүнсний хэрэглээ түгээмэл байгааг илтгэж байгаа юм. Улаанбаатар хотын 2-18 настай гурван хүүхэд тутмын нэг нь өдөр бүр чихэрлэг ундаа, хоёр хүүхэд тутмын нэг нь төрөл бүрийн чихэртэй цай, ундаа өдөр бүр уудаг гэсэн судалгаа бий. Бага насны хүүхдүүд өдөр бүр 330 мл чихэрлэг ундаа уух нь таргалах эрсдэлийг 2.8 дахин нэмэгдүүлдэг байна.

Манай улсын хувьд, хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа, шошгод олон улсын болон дотоодын хууль тогтоомжид заасан стандартыг дагаж мөрдөж байна. 2021 онд батлагдсан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савлах бөгөөд зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журмыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж хэрэгжүүлэхээр хуульчилсан. Үүний дагуу Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд болон Эрүүл мэндийн сайдын нар 2013 онд хамтран “Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам”-ыг баталсан.

Хүнсний бүтээгдэхүүний хүний биед үзүүлж болзошгүй эрсдэлийг өндөр ((=1-3), дунд ((Д)=4-8), бага ((Б)=9-14), маш бага ((МБ)=15-20 гэж зэрэглэх бөгөөд эрсдэлийн түвшин өндөртэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгонд хэрэглэх хугацаа, тээвэрлэлт, борлуулалтын онцгой нөхцөл, шаардлага, боловсруулалтын арга буюу хатаасан, огцом хөлдөөсөн, чанасан, дэвтээсэн гэх мэт мэдээллийг тусгахаар заасан байна.

Хүнсний тухай хуулиар хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангахтай холбоотой харилцааг зохицуулж байгаа бол Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал болон шошгонд тусгах үндсэн болон нэмэлт мэдээлэл, хориглох мэдээллийг нарийвчлан зохицуулсан.

Бага насны хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний чихрийн агууламжийн талаарх бодлого, эрх зүйн орчин

Монгол Улсын хувьд нялх, балчир хүүхдийг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, хяналт тавихтай холбоотой харилцаанд дараах хууль тогтоомж хэрэгжиж байна. Тухайлбал,

- Хүнсний эрх зүйн хорооноос баталсан удирдамж, стандартууд;
- Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль;
- Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам;
- “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” Монгол Улсын стандарт

“Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль”-д "нялх хүүхэд" гэж төрснөөс хойш нэг хүртэлх насны хүүхдийг, "балчир хүүхэд" гэж нэгээс гурав хүртэлх насны хүүхдийг ойлгоно[65] гэж тодорхойлжээ. Түүнчлэн 6 сартайгаас 3 хүртэлх насны хүүхдийн хүнсний найрлагад зөгийн бал болон байгалийн гаралтай чихэр агуулсан байж болохоор, транс тос, хувиргасан амьд организмаас гаралтай түүхий эд ашиглахыг хориглохоор зохицуулсан байх ба хэрэглэгчид болон эцэг, эхчүүдэд аливаа хүнсний бүтээгдэхүүний чихрийн орц, найрлагын талаарх шошго дээрх мэдээллийг зөв унших, сонголт хийхэд нь зориулж сургалтуудыг өргөнөөр зохион байгуулахаар зохицуулсан байна.

Монгол хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хэрэгжүүлдэг бөгөөд хүн амын хоол тэжээлийн үндэсний хэмжээний судалгааг 5 жил тутам гаргаж байна. 2017 онд үндэсний 5 дахь судалгааны тайланг танилцуулсан.

Бага насны хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний шошго нь шим тэжээл, орц найрлагаас гадна илүү нарийвчилсан нэмэлт мэдээллийг тавьж өгөхийг шаарддаг. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан үндсэн шаардлагаас гадна Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулиар нарийвчлан зохицуулсан байна. Дээрх хоёр хуульд заасан шаардлагыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Шошгод тавигдах шаардлага

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль
Үндсэн мэдээлэл	
• хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр; • үйлдвэрлэгчийн нэр, хаяг; • хэмжээ, тоо ширхэг, бүтээгдэхүүний цувралын дугаар; • үйлдвэрлэсэн он, сар, өдөр; • хадгалах хугацаа, эсхүл хэрэглэж дуусах хугацаа; • хадгалах нөхцөл; • тэжээллэг чанар, орц, найрлага; • хэрэглэх арга; • гаж нөлөө, хориглох заалт.	• нялх, балчир хүүхдийн хүнсний найрлага, шимт бодисын мэдээллийг сав, баглаа боодол, шошгод байршуулсан; • зориулалтын бүтээгдэхүүнд хоёр, түүнээс дээш хүнсний нэмэлтийг оруулсан бол шошго дээрх найрлагын жагсаалтад бичсэн; • хүүхдийн хүнсэнд агуулагдах бохирдуулагчийн хэмжээ нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан шаардлагыг хангасан; • хүүхдийн хүнс нь пестицид агуулаагүй.
Нэмэлт мэдээлэл	
• тусгай хоолны дэглэмтэй хүнд зориулсан хүнсний түүхий эд,	• бүтээгдэхүүнийг зөв бэлтгэх заавар; • хооллох хэрэгслийн ариутгал,

[65] Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль, 3 дугаар зүйл

бүтээгдэхүүний зориулалт, найрлага болон хэрэглэх заавар; • хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг гүйцэд боловсруулах аргачлал; • хүнсний нэмэлт, органик хүнс, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээг тавьсан байх.	цэвэрлэгээг хийх арга; • бүтээгдэхүүний орц, найрлага, агууламжийг тайлбарласан бичвэр; • үйлдвэрлэх, түгээх, борлуулах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлагатай мэдээлэл; • бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг нээхийн өмнө болон нээсний дараа хадгалах заавар.

Нэмэгдэл хоол, ундааны сав, баглаа боодол, шошгод хуульд заасан ерөнхий шаардлагаас гадна дараах мэдээллийг байршуулсан байна. Тухайлбал,

- шошгын нүүрэн хэсэгт бүтээгдэхүүнийг хэрэглэх нас;
- бэлтгэх, хадгалах горим алдагдсантай холбоотой үүсэх эрүүл мэндийн эрсдэлийг сануулсан анхааруулгыг "САНАМЖ" гарчгийн доор;
- энэ бүтээгдэхүүнийг 6 сар хүртэлх насны хүүхдэд өгч болохгүй тухай анхааруулга;
- хэрэглэх зааврын хажууд "ДАВС, ЭСХҮЛ ЧИХЭР НЭМЖ БОЛОХГҮЙ" гэсэн мэдээлэл том үсгээр.

Хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын хувьд, бага насны хүүхдэд зориулсан чихрийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүний шошгын стандарт, шим тэжээлийн болон найрлагын үзүүлэлт, шошгын стандартын асуудлыг дараах хууль тогтоомжуудаар зохицуулж байна. Тухайлбал,

Хүнсний тухай хууль (2012): Энэ хуулиар хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулдаг.

Энэхүү хуульд зааснаар “шим тэжээллэг хүнс” гэж хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх уураг, өөх тос, нүүрс ус, эрдэс бодис, амин дэм болон ашигтай бичил биетний зохистой агууламжтай хүнсийг ойлгоно гэж тодорхойлсон. "Хүнсний нэмэлт" гэж дангаараа бүтээгдэхүүн, эсхүл хүнсний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж чаддаггүй, тэжээллэг чанаргүй, амт, үнэр, өнгө оруулах, биежүүлэх, сийрэгжүүлэх, хадгалах хугацааг уртасгах болон технологи ажиллагааг хурдасгах зорилгоор хүнсний үйлдвэрлэлийн явцад зориудаар нэмдэг бодис, хольцыг хэлнэ гэж тус тус тодорхойлсон.

Монгол хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль (2012)[66]: Энэ хуулиар хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулдаг бөгөөд шошгод тусгах үндсэн болон нэмэлт мэдээллийг нарийвчлан зааж өгч, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичсэн байна. Харин дараах тохиолдолд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буруу шошголсон гэж үзнэ:

- шошго худал мэдээлэл агуулсан;

[66] https://legalinfo.mn/mn/detail/8911

- тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн өөр хүнсний нэрээр бичигдсэн;
- өөр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол ашиглан шошгыг дуурайлгаж хуурамчаар үйлдсэн;
- шошгод тавьсан шаардлагыг хангаагүй;
- мэдээллийг монгол хэлээр бичээгүй, Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээг шошгод тавиагүй;
- унших боломжгүй, ойлгомжгүй үг, өгүүлбэр, он, сар, өдөр бичигдсэн;
- ионжуулагч цацрагийн боловсруулалт хийсэн тэмдэглэгээгүй.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодол дээрх шошгыг тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон худалдаа эрхлэгч хариуцна.

Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль (2017)[67]: Энэ хуулиар хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих бодлогыг тодорхойлох, эрүүл, аюулгүй хүнсээр хангах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Нялх, балчир хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний найрлага нь олон улсын хүнсний стандарт болон хуульд заасан ерөнхий шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд хүүхдийн хүнсний дээжид даавар, антибиотик, пестицид, эмгэг төрөгч нян, хор болон бусад бохирдуулагчийн түвшинг итгэмжлэгдсэн лабораториор тогтоолгосон байхыг шаарддаг.

Нялх, балчир хүүхдэд зориулсан хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгод хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод оруулах үндсэн болон нэмэлт мэдээллийг тусгасан байх бөгөөд дараах мэдээлэл байршуулахыг хориглодог. Тухайлбал,

- бүтээгдэхүүний найрлагыг эхийн сүүний найрлага дахь шимт бодис, агууламжтай адилтгасан мэдээлэл;
- тухайн бүтээгдэхүүн хүүхэд бүрд тохирно гэсэн агуулгатай мэдээлэл;
- үйлдвэрлэгчийн лого, дүрсээр илэрхийлсэн хэрэглэх зааврааас бусад зураг, дүрс;
- бүтээгдэхүүний найрлагыг тодотгосон эрүүл мэндийн болон шим тэжээллэг чанарын тухай анхааруулга.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол[68]

Энэхүү тогтоолийн 2 дугаар зүйлд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгохоор, хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж батлуулах, хүнсний чиглэлийн бүх стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай стандарт, техникийн зохицуулалт, хүнсний сүлжээний үе шат бүрд зохистой дадлын зөвлөмж, зааврыг шинэчилж, шинээр батлахаар заасан. Харин хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тухайлбал,

- хүүхдийн хоол, сүү, ногоо, жимс, жимсгэнийн тэжээлийн үйлдвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, үндсэн түүхий эдийг дотоодоос бэлтгэн нийлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн үдийн хоолны нэг хүүхдэд ногдох зардлыг хоолны шимт байдал, инфляцын түвшинтэй уялдуулан өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тухай бүр бий болгох;

[67] https://legalinfo.mn/mn/detail/12654

[68] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530824651591

- Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нэгдсэн удирдлага зохион байгуулалттай хангамжийн цахим тогтолцоог бүрдүүлэх;
- Цэцэрлэг, сургуулийн дотуур байрны хоол үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, бэлдэц нийлүүлэх аж ахуйн нэгжийг татвар, урамшууллын бодлогоор дэмжих зэрэг болно.

“Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам” Үйлдвэр, худалдаа, аж ахуйн сайд болон Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/46/115 дугаар хамтарсан тушаал[69]

Энэхүү журмаар ил задгай борлуулах хүнсний худалдааг таслан зогсоох, хүнсний алдагдлыг багасгах, хүнснээс шалтгаалсан эрсдэлийн түвшинг бууруулах, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хүнсний сүлжээний бүх үе шатанд хөтлөх, эрсдэл гарсан шалтгаан, хугацаа, байрлал, үе шатыг тогтоох зорилгоор зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журмыг тогтоосон.

Журмаар тухайн бүтээгдэхүүнээс шалтгаалсан өвчлөл нь хүн амын дунд тархсан хүнснээс шалтгаалсан өвчлөлд эзлэх хувь хэмжээ буюу хүнсэнд агуулагдаж болзошгүй аюулын тохиолдох магадлалыг 5 ангиллаар, хүнсэнд агуулагдаж болзошгүй аюулын эрүүл мэндэд үзүүлэх хоруу чанарыг 4 түвшнээр, тухайн бүтээгдэхүүнээс хүний биед үзүүлж болзошгүй эрсдэлийг зэрэглэж, эрсдэлийн 4 түвшинг тус тус тодорхойлсон.

Эрсдэлийн түвшин өндөртэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгонд хуульд заасан үндсэн мэдээллээс гадна хэрэглэж дуусах хугацаа, тээвэрлэлт, борлуулалтын онцгой нөхцөл, шаардлага, боловсруулалтын арга /хатаасан, огцом хөлдөөсөн, чанасан, дэвтээсэн/ гэх мэт мэдээллийг тусгасан байна.

“Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” Монгол Улсын стандарт (MNS6648:2016)[70]

Энэхүү стандарт нь зайлшгүй сав, боодол хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтын шаардлагыг тогтоосон. Стандартад хүнсний бүтээгдэхүүний сав боодол, шошгололтод хамаарах 18 нэр томьёо, түүний тодорхойлолтыг хийжээ. Тухайлбал, шошго гэж хүнсний сав боодол дээр бичих, зурах, хэвлэх, товойлгох, гүн сийлэх байдлаар тэмдэглэсэн зүүлт, тамга тэмдэг, зураг болон бусад бичиглэлийг хэлнэ.

Шимт бодисын мэдээлэл гэж хүнсний бүтээгдэхүүний химийн бүрэлдэхүүн бодис (уураг, тос, нүүрс ус, аминдэм, эрдэс)-ийг ойлгоно. Чихэр /сахар/ гэж хүнсэнд агуулагдах моносахар болон дисахарыг ойлгоно гэж тодорхойлж өгсөн.

[69] https://legalinfo.mn/mn/detail?lawId=12967&sword=%D1%88%D0%BE%D1%88%D0%B3%D0%BE

[70] https://estandard.gov.mn/standard/reader/2067#8-zkiutbzbklgjakim.jpg

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Европын холбоо

- Хэрэглэгчийг хүнсний бүтээгдэхүүний мэдээллээр хангах тухай дүрэм: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:02011R1169-20180101
- Нярай болон бага насны хүүхдэд зориулсан хоол тэжээл, эмнэлгийн тусгай зориулалтын хоол хүнсний тухай тусгай дүрэм: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32013R0609
- Нялхсын хоол тэжээл, нэмэлт тэжээлд тавигдах тусгай найрлага, мэдээллийн шаардлага, нярай болон бага насны хүүхдийн хооллолттой холбоотой мэдээллийн шаардлагын талаарх нэмэлт дүрэм: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32016R0127
- Хүнсний нэмэлтийн тухай дүрэм: https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:02008R1333-20200702#tocId49
- Food labelling rules: https://europa.eu/youreurope/business/product-requirements/food-labelling/general-rules/index_en.htm
- Food labelling for Consumers: EU Law, Regulation and Policy options, 2019: https://sante.gouv.fr/IMG/pdf/food_labelling_for_consumer_eu.pdf

Австрали, Шинэ зеланд

- Review of nutrition labelling for added sugars
- https://www.foodstandards.gov.au/consumer/labelling/Documents/Review%20of%20nutrition%20labelling%20for%20added%20sugars.pdf
- Sugars on food labels https://www.sugarnutritionresource.org/the-basics/sugars-on-food-labels
- Policies in Australia https://extranet.who.int/nutrition/gina/en/policies/1377
- Food Standards Code https://www.foodstandards.gov.au/code/pages/default.aspx
- Food labelling of infant foods
- https://www.foodstandards.gov.au/publications/pages/evaluationreportseries/foodlabellingofinfantfoodsapril20049/Default.aspx
- Food law, treaties and agreements
- https://www.foodstandards.gov.au/about/foodlawandtreaties/Pages/default.aspx
- Policy Paper: Labelling of sugars on packaged foods and drinks https://foodregulation.gov.au/internet/fr/publishing.nsf/Content/C6995F10A56B5D56CA2581EE00177CA8/$File/FRSC-Policy-Paper-Labelling-of-sugars-on-packaged-foods-and-drinks-2019-06.pdf
- Nutrition labels and health claims: the global regulatory environment https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/42964/9241591714.pdf;jsessionid=B8F7993CAEF2B4CF3E25432867E30996?sequence=1
- Policy guideline on food labelling to support consumers to make informed healthy food choices
- https://foodregulation.gov.au/internet/fr/publishing.nsf/Content/1545CC0E4B5C25BDCA25860F007FCA12/$File/Forum-Policy%20Guideline%20on%20food%20labelling-2020-08.pdf

АНУ

- 21 CFR Part 10, Food Labeling: Revision of the Nutrition and Supplement Facts Labels https://extranet.who.int/nutrition/gina/sites/default/filesstore/USA%202016%20Food%20Labeling.pdf
- Uniform Compliance Date for Final Food Labeling Regulations Issued in 2021 and 2022 January 2021
- Food Labeling Guide https://www.fda.gov/files/food/published/Food-Labeling-Guide-%28PDF%29.pdf
- Code of Federal Regulations 101.9 Nutrition labeling of food https://www.ecfr.gov/current/title-21/chapter-I/subchapter-B/part-101/subpart-A/section-101.9
- Dietary Guidelines for Americans 2020-2025 https://www.dietaryguidelines.gov/sites/default/files/2020-12/Dietary_Guidelines_for_Americans_2020-2025.pdf
- Guidance for Industry: Nutrition and Supplement Facts Labels: Questions and Answers Related to the Compliance Date, Added Sugars, and Declaration of Quantitative Amounts of Vitamins and Minerals Revised December 2019
- Guidance for Industry: Policy Related to Cranberry Products with Added Flavorings August 2019
- Guidance for Industry: Declaration of Added Sugars on Honey, Maple Syrup, Other Single-Ingredient Sugars and Syrups, and Certain Cranberry Products June 2019
- Overview of Food Ingredients, Additives & Colors https://www.fda.gov/food/food-ingredients-packaging/overview-food-ingredients-additives-colors#types https://www.ecfr.gov/current/title-21/chapter-I/subchapter-B/part-101/subpart-D/section-101.60#p-101.60(c)(1)

БНСУ

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага https://extranet.who.int/nutrition/gina/en/policies/1470
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) https://www.fao.org/food-labelling/en/
- Korean law information center www.law.go.kr
- Ministery of Food and Drug safety https://www.mfds.go.kr/eng/brd/m_15/list.do
- Invisible numbers:the true extent of noncommunicable diseases and what to do about them https://www.who.int/teams/noncommunicable-diseases/invisible-numbers

Канад Улс

- Food and Drugs Act https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/f-27/page-1.html
- Foods for Infants Six Months of Age or Older but Less Than One Year of Age https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/c.r.c.%2C_c._870/page-12.html#h-568940
- Nutrition Labeling https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/C.R.C.%2C_c._870/page-54.html#h-1372046
- Core. Information https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/C.R.C.%2C_c._870/page-54.html#h-1372046
- Nutrition Labeling https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/c.r.c.,_c._870/page-10.html#h-568846
- Safe Food for Canadians Act https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/S-1.1/FullText.html
- Consumer Packaging and Labeling Act https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/C-38/FullText.html

- Canadian Food Inspection Agency https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-16.5/page-1.html#h-68016
- Thresholds Requiring a Nutrition Symbol https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/C.R.C.,_c._870/page-9.html#h-1371245
- Sugars in the nutrition facts table https://www.canada.ca/en/health-canada/services/food-labelling-changes/sugars.html
- Canadian Sugar Institute https://sugar.ca/about-us/strategic-priorities

Монгол Улс

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://legalinfo.mn/mn/detail?lawId=12967&sword=%D1%88%D0%BE%D1%88%D0%B3%D0%BE
- Стандарт, хэмжил зүйн газарhttps://estandard.gov.mn/standard/reader/2067#8-zkiutbzbklgjakim.jpg
- Монцамэ агентлаг https://montsame.mn/mn/read/194125
- “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн тулгамдсан асуудал” үндэсний V судалгааны тайлан, ЭМЯ, НЭМҮТ, НҮБ-ын Хүүхдийн сан, 2017 он https://www.unicef.org/mongolia/media/1121/file/NNS_V_Sedevchilsen_tailan_MN.pdf

Бусад

- British heart foundation https://www.bhf.org.uk/informationsupport/heart-matters-magazine/nutrition/sugar-salt-and-fat/names-for-sugar-infographic
- Food and Agriculture Organization (FAO) https://www.fao.org/about/en/
- Codex alimentarius international food standards https://www.fao.org/fao-who-codexalimentarius/about-codex/en/
- World health organization https://www.who.int/teams/noncommunicable-diseases/invisible-numbers
- Guideline: sugars intake for adults and children https://www.who.int/publications/i/item/9789241549028
-